

## ҮГИЙН ТАЙЛБАР

*Note: the ICP material will contain links to glossary definitions*

№	Нэр томьёо	Дэлгэрэнгүй тайлбар	Дахин найруулга
1	<b>Actuary</b> – <b>Актуарч</b>	An actuary is a professional trained in evaluating the financial implications of contingency events. Actuaries require an understanding of the stochastic nature of insurance and other financial services, the risks inherent in assets and the use of statistical models. In the context of insurance, these skills are, for example, often used in establishing premiums, technical provisions and capital levels.	Актуарч нь санамсаргүй тохиолдлын санхүүгийн нөлөөллийг тооцдог мэргэжилтэн. Актуарч нь даатгалын болон санхүүгийн бусад үйлчилгээний стохастик мөн чанар, хөрөнгөтэй холбоотой эрсдэл, статистик загваруудыг ашиглах чадвартай байх бөгөөд даатгалд үүнийг хураамж, нөөц болон хөрөнгийн оновчтой хэмжээг тогтооход ихэвчлэн ашигладаг.
2	<b>Actuarial report</b> - <b>Актуарчийн тайлан</b>	A written report provided by the actuary on one or more aspects of the company's operations (for example, the company's calculation of premiums and/or technical provisions etc).	Актуарч нь компанийн үйл ажиллагааг (хураамжийн тооцоололт, техникийн нөөц гэх мэт) нэг ба олон талаас нь харж бэлтгэсэн бичгээр гаргасан албан ёсны тайлан.
3	<b>Aggregate excess of loss reinsurance (Stop-loss)</b> – <b>Нийт босгоос давсан хэсгийн давхар даатгал/Алдаг длыг зогсоох давхар даатгал</b>	This method of reinsurance provides reinsurer indemnification to the ceding company for the aggregate amount of losses during a specific time frame up to a predetermined limit or percentage. For these situations, the ceding company will be expected to provide documentation to the reinsurer of the premiums collected and the losses sustained.	Давхар даатгалын энэ аргаар, даатгалын компанид тодорхой хугацаанд учирсан нийт хохирлыг давхар даатгагч нь урьдчилан тохиролцсон хэмжээгээр нөхөн төлдөг. Энэ тохиолдолд даатгалын компани нь давхар даатгагчид даатгалын хураамж болон учирсан хохирлын талаарх баримт материалыг хүргүүлэх шаардлагатай.
4	<b>Alternative risk transfer (ART)</b> – <b>Эрсдлийг тараах хувилбарт арга хэрэгсэл</b>	Any form of risk transfer that includes at least an element of insurance risk, rather than purely financial risk. Possible features of ART include, but are not restricted to: • Tailor-made solutions • Multi-year policies • Often the coverage of risks that the conventional market would regard as uninsurable • Often the inclusion of some form of risk transfer of non-insurance risk The definition of ART includes, but is not restricted to, finite reinsurance and securitization of insurance risks.  [Related definitions: <i>Reinsurance</i> ]	Санхүүгийн цэвэр эрсдлээс гадна даатгалын эрсдлийн элементийг тодорхой хэмжээгээр багтаасан эрсдэл шилжүүлэх арга. Энэ арга нь дор хаяж дараахь шинжүүдийг агуулсан байдаг: - захиалгад нийцсэн байх; - олон жилийг хамарсан байх; - уламжлалт зах зээлд даатгуулах боломжгүй гэж тооцогддог эрсдлүүдийн хамгаалах боломжтой; - Даатгалын бус эрсдлийг шилжүүлэх зарим хэлбэрийг агуулсан байх.  Эрсдэл тараах хувилбарт арга хэрэгслийг тодорхойлохдоо финит давхар даатгал болон даатгалын эрсдлийг хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдээр баталгаажуулсан хамгаалалтыг ч мөн багтаасан байдаг. / Холбоотой нэр томъёо: Давхар даатгал/
5	<b>Asset-liability management (ALM)</b> - <b>хөрөнгө-өр төлбөрийн удирдлага</b>	The practice of managing an insurer so that decisions and actions taken with respect to assets and liabilities are coordinated through the ongoing process of formulating, implementing, monitoring and revising strategies related to assets and liabilities to achieve an insurer's financial objectives, given its risk tolerances and other constraints.	Даатгагчийн хөрөнгө, эх үүсвэртэй холбоотой стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, сайжруулах байнгын үйл ажиллагаатай уялдуулан даатгалын компанийг удирдах практик. Хөрөнгө, эх үүсвэртэй холбоотойгоор хэрэгжүүлж буй шийдвэр болон арга хэмжээнүүд нь даатгагчийн эрсдэл даах чадвар болон бусад шаардлагуудад нийцсэн байна.
6	<b>Auditor's report</b> – <b>Аудиторын тайлан</b>	Written opinion expressed by the auditor on his/her examination of the company's general purpose financial reports.	Компанийн санхүүгийн тайланд хяналт шалгалт хийсний үндсэн дээр аудиторийн бичгээр гаргасан санал дүгнэлт
7	<b>Automatic life</b>	Similar to non-life "treaty" reinsurance. In	Энэ нь амьдралын бус даатгалын “гэрээт”

	<b>reinsurance – заавал хэрэгжүүлэх амьдралын даатгалын давхар даатгал</b>	automatic reinsurance, the ceding company is able to bind the reinsurer on a risk without submitting an application for reinsurance provided certain conditions are met. These conditions vary by agreement, but typically obligate the ceding company to keep retention on the life, limit the amount of insurance on a life that may be ceded, and limit the overall amount of insurance that may be in force on the life issued by all life insurers. The ceding company may be required to notify the reinsurer of automatic reinsurance arrangements through specific cessions (i.e., "cession reporting"), otherwise it is called "bordereau reporting." This type of reinsurance will be typically offered to broad segments of a insurer's business, such as all issues of a specified policy form.	давхар даатгалтай төстэй. Гэрээт давхар даатгалаар гэрээний нөхцлийг хангасан тохиолдолд даатгуулагч компани нь давхар даатгуулах өргөдөл, хүсэлт гаргахгүйгээр давхар даатгагчид эрсдлээ шууд шилжүүлэх боломжтой болдог. Эдгээр нөхцөлүүд нь гэрээ бүрт өөр өөр байх боловч даатгалын компани нь эрсдэл бүрт өөрт үлдээх хариуцлагын хэсэгтэй байх, шилжүүлэх эрсдэл бүрийн үнэлгээг хязгаарлах, амьдралын даатгалын бүх компаниудын хийсэн хүчин төгөлдөр нийт даатгалын үнэлгээнд хязгаар тавих үүрэг хүлээдэг. Давхар даатгуулагч компани нь давхар даатгагчдаа нарийвчилсан мэдээлэл бүхий "шилжүүлгийн тайлан" буюу "бордеро тайлан" өгдөг.
8	<b>Back-testing – буцаан хянах сорил</b>	A process of comparing the predictions from a model with actual experience in order to determine whether actual results, over a reasonable period of time are within the expected range produced by the model.	Боломжит хугацааны дараахь бодит үр дүн нь таамаглалын дагуу гаргасан хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тодорхойлох үйл явц
9	<b>Basis risk – суурь эрсдэл</b>	The risk that yields on instruments of varying credit quality, marketability, liquidity and maturity do not move together, thus exposing the insurer to market value variation that is independent of liability values.	Эх үүсвэрийн хэмжээнээс хамааралгүйгээр зах зээлийн үнэ цэнийн өөрчлөлтөөс даатгагчид аюул учирч болох, зээлийн чанар, борлогдох боломж, хөрвөх чадвар болон эргэн төлөгдөх хугацаа зэрэг хэрэгслүүдийн нөлөөгөөр үүсэх эрсдэл
10	<b>Board of Directors (Board) – Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/</b>	A body of elected or appointed individuals ultimately responsible for the governance and oversight of the company.	Компанийн засаглал болон хяналтын эцсийн үр дүнг хариуцах үүрэг бүхий сонгогдсон, эсхүл томилогдсон хүмүүс.
11	<b>Calibration test – тохируулах сорил</b>	A test to demonstrate that the regulatory capital requirement determined by the internal model satisfies the specified modeling criteria.	Зохицуулах байгууллагаас шаардсан хөрөнгө нь холбогдох дүрэм, журамд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг нотлох сорил.
12	<b>Capital хөрөнгө</b>	The financial resources of an insurer and different variation/calculations of capital may be referred to as equity capital (i.e. paid-up, share, subscribed), economic capital and regulatory capital.	Даатгагчийн санхүүгийн нөөц бөгөөд хувьцаа эзэмшигчдийн өмч, дүрмийн сан гэх мэт хөрөнгийн эх үүсвэр хамаарна.
13	<b>Capital add-on-Нэмэлт хөрөнгө</b>	An additional capital requirement imposed by the supervisor to address, for example, any identified weaknesses in an internal model or other more tailored approach as a condition on its use or in the context of a review of the ongoing validity of an internal model for regulatory capital purposes.	Зохицуулалтын байгууллагаас тухайн байгууллагын дотоод дахь сул тал болон зарим зөрчилтэй холбогдуулан нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн өөрийн хөрөнгийн хэмжээ.
14	<b>Capital adequacy – Хөрөнгийн зохистой байдал</b>	The adequacy of capital resources relative to regulatory capital requirements.	Зохицуулах байгууллагын шаардлагыг хангасан өөрийн хөрөнгийн зохистой байдал.
15	<b>Capital resources – хөрөнгийн эх үүсвэр</b>	Financial resources that are capable of absorbing losses.	Алдагдлыг нөхөх боломжтой санхүүгийн эх үүсвэрүүд
16	<b>Captive insurer</b>	An insurance or reinsurance entity created	

	<p>– <b>/Каптив даатгагч/</b></p>	<p>and owned, directly or indirectly, by one or more industrial, commercial or financial entities, the purpose of which is to provide insurance or reinsurance cover for risks of the entity or entities to which it belongs, or for entities connected to those entities and only a small part if any of its risk exposure is related to providing insurance or reinsurance to other parties.</p> <p>In practice, supervisors in captive jurisdictions tend to use the following classifications:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Pure captives: single parent companies writing only the risks of their owner and/or affiliates;</li> <li>• Group and/or association captives: multi-owned insurance companies writing only the risks of their owners and/or affiliates, usually within a specific trade or activity;</li> <li>• Rental captives: insurers specifically formed to provide captive facilities to unrelated bodies for a fee. They are used by entities that prefer not to form their own dedicated captive;</li> <li>• Diversified captives: captives writing a limited proportion of unrelated business in addition to the risks of their owner and/or affiliates. Some jurisdictions consider that an insurance company writing any unrelated party business cannot be classified as a captive."</li> </ul>	<p>Тодорхой нэг байгууллагад харъяалагддаг, эсхүл түүнтэй холбоотой байгууллагуудын эрсдлийг даатгал, давхар даатгалд хамруулах зорилгоор нэг, эсхүл хэд хэдэн санхүү, үйлдвэр, худалдааны байгууллагаас шууд ба шууд бусаар үүсгэн байгуулж, өмчилсөн даатгал, эсхүл давхар даатгалын байгууллагыг каптив даатгагч гэнэ.</p> <p>Зохицуулалтын байгууллагууд каптив даатгагчдыг ихэвчлэн дараах байдлаар ангилдаг: <u>Цэвэр каптив даатгагч</u> - Зөвхөн өөрийн өмчлөгчдийн, эсхүл өмчлөгчтэй нэгдмэл сонирхолтой компаниудын эрсдлийг даатгадаг толгой компани.</p> <p><u>Бүлэг, эсхүл холбоо каптив даатгагч</u>: Зөвхөн өөрийн өмчлөгчдийн, эсхүл тэдгээрийн салбарын тодорхой үйл ажиллагааны эрсдлүүдийг даатгадаг олон өмчлөгчтэй даатгагчид</p> <p><u>Түрээсийн каптив даатгагч</u>: Тодорхой төлбөр авсны үндсэн дээр өөртэйгээ холбоо хамааралгүй этгээдийг даатгах зорилго бүхий даатгагч. Тусгайлан каптив даатгагч байгуулах сонирхолгүй компаниуд энэ төрлийн каптив даатгагчийг ашигладаг.</p> <p><u>Олон талт каптив даатгагч</u>: Өмчлөгч, эсхүл нэгдмэл сонирхолтой компаниудын эрсдлийг даатгахаас гадна, өөрт хамааралгүй этгээдийг тодорхой хувиар даатгалд хамруулдаг каптив. Зарим улсын хуулиар өөрт хамааралгүй этгээдийн бизнесийг даатгадаг даатгалын компанийг каптив гэж үздэггүй.</p>
17	<p><b>Catastrophe reinsurance (life and health) – гамшгийн давхар даатгал /амьдралын болон эрүүл мэндийн даатгал/</b></p>	<p>This provides for payment by the reinsurer when the ceding company's aggregate net retained claims resulting from a single accidental event exceed the insurer's retention under the reinsurance agreement. Commonly the reinsurer pays something less than 100% of such excess, the balance being retained by the insurer, and a limit is placed on the amount the reinsurer will pay on any one catastrophe. An annual limit may also be placed on the total amount to be paid by the reinsurer. The coverage may be purchased on the ceding company's entire portfolio of retained risks or on any readily definable category, such as all retained individual risks, a particular group case, a category of group cases, etc. Normally, both the regular life insurance risk and the accidental death risk will be included.</p>	<p>Даатгалын нэг тохиолдлын улмаас давхар даатгуулагчийн өөрт үлдээсэн хариуцлагын хэмжээ гэрээгээр тохиролцсон хэмжээнээс давсан тохиолдолд давхар даатгагчаас нөхөн төлбөр төлөх давхар даатгал.</p> <p>Давхар даатгагч нь даатгуулагч компанийн хүлээх эрсдлээс давсан хэсгийн 100 хүртэл хувийг нөхөн төлдөг ба энэ хэмжээ нь ямар нэг гамшгийн тохиолдлын улмаас үүсэх хохиролд давхар даатгагчаас төлөх хэмжээгээр хязгаарлагдах бөгөөд давхар даатгагчийн жилд төлөх нийт хэмжээг тогтоож болдог.</p> <p>Энэ хамгаалалтыг даатгалын компанийн өөртөө үлдээсэн хариуцлагын нийт багцад, эсхүл тухайлан ангилсан ангилалаар /тухайлбал, өөрт үлдээсэн хариуцлага тус бүрээр, тодорхой бүлэг хүмүүсийн тохиолдлоор, бүлэг хүмүүсийн тохиолдлын ангилал гэх мэт/ авч болдог.</p> <p>Ер нь амьдралын даатгалын болон гэнэтийн ослын улмаас нас барах эрсдэл аль аль нь багтдаг.</p>
18	<p><b>Churning зохисгүй</b></p>	<p>– The practice of selling insurance policies to a policyholder which unnecessarily</p>	<p>Даатгалын гэрээг тодорхой шалтгаангүйгээр шаардлагагүй байхад дахин шинэчлэх замаар</p>

	<b>борлуулалт</b>	replace existing policies, for the purpose of increasing turnover - usually to generate commission.	даатгалын гэрээ борлуулах үйл ажиллагаа. Энэ нь борлуулалтын эргэлтийг нэмэгдүүлэх, ихэнхдээ даатгалын борлуулалтын шимтгэл авах зорилго агуулсан байдаг.
19	<b>Claims development triangle – нэхэмжлэлийн хөгжлийн гурвалжин</b>	The triangle showing the insurer's estimate of the cost of claims (claims provisions and claims paid) as of the end of each accident year/underwriting year and how this estimate develops over time. [Related definitions: <i>Claims provision, Underwriting year basis.</i> ]	Даатгагчийн нэхэмжлэлийн зардлын (нэхэмжлэлийн нөөц ба нөхөн төлбөр) тооцооллыг ослын/андеррайтинг жил бүрээр харуулахын зэрэгцээ тэдгээр нь цаг хугацааны явцад хэрхэн үргэлжлэхийг харуулсан гурвалжин.  / Холбоотой нэр томъёо: нэхэмжлэлийн нөөц, андеррайтингийн жилд суурилсан/
20	<b>Claims incurred – учирсан хохирлын нэхэмжлэл</b>	An insurer's total liability arising from insurance events related to an accounting period either on an accident year basis or on an underwriting year basis. [Related definitions: <i>Loss ratio, Underwriting year basis.</i> ]	Ослын, эсхүл андеррайтинг жилд суурилсан нягтлан бодох бүртгэлийн хугацаанд хамаарч байгаа даатгалын тохиолдлын улмаас үүсэх даатгагчийн хүлээх нийт хариуцлагын хэмжээ. [Холбоотой нэр томъёо: хохирол нөхөлтийн харьцаа, андеррайтингийн жилийн суурь/]
21	<b>Claims provision – хохирлын нэхэмжлэлийн нөөц</b>	Amount set aside on the balance sheet to meet the total estimated ultimate cost to an insurer of settling all claims arising from events which have occurred up to the end of the reporting period, whether reported or not, less amounts already paid in respect of such claims. [Equivalent terms: <i>Claim reserves.</i> ] [Related definitions: Claims development triangle, Underwriting year basis]	Нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тайлангийн хугацаанд учирсан даатгалын тохиолдлын улмаас үүсэх даатгагчийн тооцсон нэхэмжлэлийн нийт зардлаас төлсөн нэхэмжлэлийн зардлыг хассан, санхүүгийн үлдэгдлийн тэнцэлд тусгагдсан дүн. /Холбоотой нэр томъёо: Нэхэмжлэлийн гурвалжин, андеррайтингийн жилд суурилсан/
22	<b>Claim reserves – хохирлын нэхэмжлэлийн нөөц</b>	see <b>Claims provision</b>	"Нэхэмжлэлийн нөөц" тайлбарыг харна уу.
23	<b>Coinsurance basis – хамтын даатгалд суурилсан</b>	This type of reinsurance is considered to be the most comprehensive basis since it usually involves transfer of a portion of all the risks inherent in the original business on a quota share or excess of retention basis from the ceding company to the reinsurer. In this type of reinsurance, the insurer and the reinsurer share a portion of the risks under the original insurance policy. The reinsurer receives a portion of the gross paid policy premiums based on the amount of risk assumed and establishes a correlating reserve. In addition to fulfilling the assumed portion of the claim, the reinsurer is also required to reimburse the insurer for any other benefits provided under the policy (i.e., policy dividends, commissions, premium taxes, etc.). The reinsurer also provides the ceding insurer with a commission to cover the marketing, underwriting and distribution aspects of the policy.	Хамтын даатгалд суурилсан давхар даатгал нь хамгийн өргөн ашиглагддаг бөгөөд даатгуулагч компаниас анхны даатгалын гэрээний бүхий л эрсдлийн тодорхой хувийг хувь оролцооны, эсхүл өөрт үлдэх хэсгээс давсан хэлбэрээр давхар даатгагчид шилжүүлэх үйл ажиллагаа юм.  Энэ даатгалаар даатгагч болон давхар даатгагч нь эрсдлээ тодорхой хувиар хуваан хариуцах бөгөөд давхар даатгагч хүлээсэн хариуцлагадаа харгалзах хураамжийг авч, нөөц байгуулдаг.  Давхар даатгагч хүлээсэн үүргийнхээ дагуу учирсан хохиролд нөхөн төлбөр төлөхөөс гадна гэрээний дагуу ногдол ашиг, шимтгэл, хураамжийн татвар гэх мэт бусад зардалд зориулан төлбөр төлөх үүрэгтэй.  Давхар даатгагч нь мөн даатгагчийн маркетинг, даатгалын борлуулалт, түгээлтийн зардалд зориулан тодорхой хэмжээний шимтгэлийг төлдөг.
24	<b>Coinsurance with funds withheld – Шилжүүлээгүй сан бүхий</b>	A slight variation of the coinsurance basis method may occur if assets are retained by the insurer. Under this method, the insurer withholds assets supporting the reserves on the ceded portion of the	Энэ нь даатгагч даатгалын хураамжийг давхар даатгагчид шилжүүлэхгүйгээр өөрт авч үлддэгээрээ хамтын даатгалд суурилсан давхар даатгалаас ялгаатай.  Даатгагч давхар даатгагчид шилжүүлсэн



	<b>хам даатгал</b>	business and the insurer sets up an interest bearing amount payable to the reinsurer. Under these circumstances, the ceding company may wish to retain control of the funds arising from its own policies either to maximise its own investment returns, or as security against the event that the reinsurer's ability to discharge its obligations to the ceding insurer becomes impaired.	эрсдлийн нөөцөд зориулсан мөнгөн хөрөнгийг өөртөө авч үлдэх бөгөөд энэ хэсэгт тодорхой хүү тооцсон дүнгээр давхар даатгагчид төлөх өглөг үүсгэдэг.  Энэ тохиолдолд, давхар даатгуулагч нь хөрөнгө оруулалтын өгөөжөө нэмэгдүүлэх, эсхүл давхар даатгагч үүргээ биелүүлэх чадваргүй болох эрсдлийг хаах зорилгоор гэрээний орлогоо өөрөө бүрэн хянах сонирхолтой байдаг.
25	<b>Collateral барьцаа хөрөнгө</b>	– Assets held as security in support of a promise to the payment of a debt or performance of a contract.	Гэрээний үүргийн биелэлт, эсхүл өр төлбөрөө төлөх амлалтын баталгаа болгон авсан хөрөнгө
26	<b>Combined ratio – хосолсон харьцаа</b>	– The sum of the loss ratio (claims ratio) and the expense ratio.	Хохирол нөхөлт ба зардлын харьцааны нийлбэр
27	<b>Consumer хэрэглэгч</b>	– The universe of all actual and potential customers for insurance products.	Даатгуулсан болон даатгуулах боломжтой бүх хэрэглэгч.
28	<b>Contagion дам нөлөөлөл</b>	– As part of a group or conglomerate, and aside from intragroup exposures of a financial nature, there may be a risk that the support of the insurer by internal or external parties may suffer if there is a concern about another part of the group of which it is a part. [Related definition: <i>Risk concentration</i> ]	Компанийн нэгдлийн нэг хэсэг болохын хувьд нэгдлийн дотоод санхүүгийн нөхцөл байдлаас гадна гадаад, дотоод аливаа нөлөөллийн улмаас даатгагч нь компанийн нэгдэлд үзүүлэх нөлөөлөл
29	<b>Continuity analysis тасралтгүй байдлын шинжилгээ</b>	– An analysis of an insurer's ability to continue in business, the risk management and financial resources required to do so over a longer time horizon than typically used to determine regulatory capital requirements.	Зохицуулах байгууллагаас тавьдаг хөрөнгийн шаардлагаас гадна даатгагчийн урт хугацаан дахь бизнесээ үргэлжлүүлэн авч явах чадвар, эрсдлийн удирдлага болон санхүүгийн нөөцийн шинжилгээ.
30	<b>Continuum-based approach-Чанарт суурилсан хандлага</b>	<i>Involves the setting of characteristics against which individual capital elements can be assessed as to their quality; instruments are ranked against other instruments to determine whether they are included as capital resources. Where a categorization approach is used, the criteria will be used to determine the category of capital resources in which a capital element is included.</i>	Энэ нь хөрөнгийн чанарыг үнэлэх төлөвийг тодорхойлсны үндсэн дээр зэрэглэж хөрөнгийн эх үүсвэрт багтаах шийдвэр гаргах ажиллагааг багтаадаг.
31	<b>Control functions Хяналтын функцууд</b>	– Refers to properly authorized functions, whether in the form of a person, unit or department, serving a control or checks and balances function from a governance standpoint and which carry out specific activities including risk management, compliance, actuarial matters, and internal audit.	Засаглалын байр сууринаас үйл ажиллагаа явуулдаг алба хэлтэс, нэгж, хувь хүнд зохих хууль дүрмийн дагуу эрх олгогдсон хяналт тавих, шалгах, тогтворжуулах зэрэг чиг үүргүүд. Үүнд эрсдлийн удирдлага, хууль, дүрэм, журам дагаж мөрдүүлэх, актуар тооцоолол болон дотоод аудит зэрэг үйл ажиллагаа хамаарна.
32	<b>Control level – Хяналтын түвшин</b>	– A threshold solvency level that requires intervention of the supervisor or imposes certain restrictions on the insurer if the actual solvency level falls below this level.	Энэ нь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн босго. Даатгагчийн төлбөрийн чадвар зохих түвшнээс доогуур болсон тохиолдолд даатгагчийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх гэх мэт Зохицуулалтын байгууллагын хөндлөнгийн оролцоо ордог.
33	<b>Corporate governance компанийн засаглал</b>	– Refers to systems (such as strategies, policies, processes and controls) through which an entity is managed and controlled.	Байгууллагыг удирдах, хянах тогтолцоо /стратег, бодлого, үйл ажиллагаа, хяналт гэх мэт/
34	<b>Counterparty Ажил хэргийн</b>	– The other party with whom a transaction is made.	Аливаа хэлцлийн нөгөө тал

	<b>түнш:</b>		
35	<b>Counterparty credit risk – Ажил хэргийн түншийн зээлийн эрсдэл</b>	The risk that a counterparty is not able or willing to pay amounts owing to the insurer as they fall due	Ажил хэргийн түнш нь даатгагчид төлөх төлбөрөө хугацаанд нь төлөх чадваргүй, эсхүл төлөхөд бэлэн бус байх эрсдэл.
36	<b>Credit default risk – зээлийн үл гүйцэтгэлийн эрсдэл</b>	The risk that an insurer will not receive the cash or assets to which it is entitled because a party with which the insurer has a bilateral contract defaults on one or more obligations.	Даатгагчтай гэрээ байгуулсан этгээд үүргээ гүйцэтгээгүйгээс даатгагч мөнгө болон хөрөнгөө авах боломжгүй болох эрсдэл.
37	<b>Credit ratings – зээлжих зэрэглэл</b>	Assessments of the abilities of debtors (e.g. bond issuers) to pay amounts owing to investors as they fall due.  [Related definition: <i>Rating agency</i> ]	Зээлдэгч /бонд гаргагч гэх мэт/ нь хөрөнгө оруулагчдад төлбөрөө хугацаанд нь төлөх чадварын үнэлгээ Холбоотой нэр томъёо - Үнэлгээ тогтоох агентлаг
38	<b>Credit risk – зээлийн эрсдэл</b>	The risk of financial loss resulting from default or movements in the credit rating assignment of issuers of securities (in the insurer's investment portfolio), debtors (e.g. mortgagors), or counterparties (e.g. on reinsurance contracts, derivative contracts or deposits) and intermediaries, to whom the company has an exposure. Credit risk includes default risk, downgrade or migration risk, indirect credit or spread risk, concentration risk and correlation risk. Sources of credit risk include investment counterparties, policyholders (through outstanding premiums), reinsurers, intermediaries and derivative counterparties.	Даатгагчийн хөрөнгө оруулалтын багцад байгаа үнэт цаас гаргагч, мөн зээлдэгч (ипотекийн зээлдэгч г.м), ажил хэргийн түнш (давхар даатгалын болон үүсмэл үнэт цаасны гэрээний, эсхүл хадгаламжийн г.м) болон зуучлагч нь гэрээний үүргээ биелүүлж чадахгүй болох, эсхүл зээлжих зэрэглэлийн өөрчлөлтөөс хамаарч даатгагчид учрах санхүүгийн эрсдэл.  Зээлийн эрсдэлд гэрээний үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл, зэрэглэл буурах буюу шилжилтийн эрсдэл, шууд бус зээлийн буюу тархалтын эрсдэл, төвлөрлийн эрсдэл болон хамаарлын эрсдлүүд багтана.  Зээлийн эрсдэл нь хөрөнгө оруулалтын түншүүд, хураамжаа бүрэн төлөөгүй даатгалын гэрээ эзэмшигчид, давхар даатгагчид, зуучлагчид болон санхүүгийн үүсмэл үнэт цаасны харилцагчидтай холбоотойгоор үүсдэг.
39	<b>Cross border provision of services – хил дамнасан үйлчилгээ үзүүлэх нөхцөл</b>	Provision of insurance on a services basis (without local establishment) in a jurisdiction other than the company's home jurisdiction.	Өөрийн харьяалагдах улсын хуулиас бусад улсад тухайн улсын хуулийн дагуу даатгалын үйлчилгээ үзүүлэх нөхцөл /тухайн улсад бүртгэлгүй компани/
40	<b>Currency risk – ханшийн эрсдэл</b>	The risk that arises from movements in foreign currency exchange rates. This can arise if the assets and liabilities of an insurer are not in the same currency, or if contracts for administrative and other services are contracted in a currency different to the currency implied in the premium determination. Also, in some jurisdictions, the sale of contracts in other than the local currency leads to an impact on rates of persistency / discontinuance in the event that the policyholders are exposed to a mismatch.	Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл.  Энэ нь даатгагчийн хөрөнгө, эх үүсвэр нь ижил мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдээгүй байх, удирдлагын болон бусад үйлчилгээний гэрээ нь даатгалын хураамжийн тооцоонд ашигласан мөнгөн тэмдэгтээс өөр мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн байх зэрэг шалтгаанаар үүсдэг.  Зарим орны хуулиар, үндэсний мөнгөн тэмдэгтээс өөр валютаар гэрээ хийх нь тухайн бизнесийн тасралтгүй байдлын зэрэглэлд нөлөөлдөг. Энэ зэрэглэл нь даатгалын гэрээ эзэмшигчдийн дунд ялгаатай нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй холбоотой.
41	<b>Current estimate –</b>	The probability weighted average of the range of present values of the cash flows	Даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой үүсэх мөнгөн

	<b>одоогийн үнэлгээ</b>	associated with fulfilling an insurer's obligations under an insurance policy. For some types of insurance liability, it may be considered that the projection of future cash flows is unrealistic, and therefore presents a spurious level of accuracy in the estimate. For such examples the alternative estimate should be arrived at using similar considerations regarding the obligations of the contract as for those examples where projected cash flows are realistic. [Related terms: <i>Margin over the Current Estimate (MOCE), Technical provision</i> ]	гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн жигнэсэн дундаж.  Даатгалын хариуцлагын зарим төрлийн хувьд ирээдүйн мөнгөн урсгалын тооцоолол нь бодит бус байж болох тул хэт нарийвчлалтай тооцоо нь үнэлгээнд алдаа гаргадаг.  Ийм тохиолдолд, мөнгөн урсгалын төлөвлөлт нь бодит байх гэрээний үүргүүдийн дагуу ойролцоо төсөөллийг ашиглан өөр үнэлгээ хийнэ.  [Холбоотой нэр томъёо: өнөөгийн төсөөллөөс дээшхи хязгаар- <i>Margin over the Current Estimate (MOCE), техникийн нөөц</i> ]
42	<b>Customer харилцагч</b> –	Policyholder or prospective policyholder with whom an insurer or insurance intermediary interacts, and includes, where relevant, other beneficiaries and claimants with a legitimate interest in the policy.	Даатгагч болон даатгалын зуучлагчтай хамтран ажиллаж буй даатгалын гэрээ эзэмшигч, эсхүл ирээдүйн боломжит даатгалын гэрээ эзэмшигч, тэдгээртэй холбогдох нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд болон хууль ёсны бусад нэхэмжлэгчид багтана.
43	<b>Derivative дериватив /санхүүгийн үүсмэл үнэт цаас/</b> –	A derivative is a financial asset or liability whose value depends on (or is derived from) other assets, liabilities or indexes (the "underlying asset"). Derivatives are financial contracts and include a wide assortment of instruments, such as forwards, futures, options, warrants, swaps and composites.	Үнэ цэнэ нь бусад хөрөнгө, хариуцлага, эсхүл тодорхой индекс /суурилах хөрөнгө/-ээс хамаардаг санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дериватив гэнэ.  Дериватив нь санхүүгийн хэлцэл бөгөөд үүнд форвард, фьючерс, опшин, баталгаа, своп болон бусад нийлмэл хэрэгслүүд ордог.
44	<b>Deterministic scenario-детерминистик хувилбар</b>	An event, or a change in conditions, with a set probability in which the underlying assumptions are fixed. [Related definitions: <i>Stress test, Scenario test, Stochastic modelling</i> ]	Суурь таамаглалууд нь тогтмол байх магадлалтай үйл явдал, эсхүл нөхцөл байдлын өөрчлөлт. Холбоотой нэр томъёо: стресс сорил, хувилбарт сорил, стохастик загварчлал
45	<b>Direct approach – шууд хандлага</b>	A supervisory approach to non-regulated entities which entails licensing or authorization of entities in an insurance group which do not themselves provide insurance services.	Даатгалын зохицуулалтын хүрээний бус боловч даатгалын группт багтдаг байгууллагуудыг хянах, түүнчлэн зөвшөөрөл авахыг байхыг шаарддаг хяналтын хандлага.
46	<b>Double gearing – давхар тохируулга</b>	Used to describe a situation where the same capital is used simultaneously as a buffer against risk in two or more legal entities of a conglomerate.	Компанийн нэгдлийн хоёр ба түүнээс дээш хуулийн этгээдийн эрсдлийг хамгаалах зорилгоор нэг хөрөнгийг нэгэн зэрэг давхардуулан ашиглахад хэрэглэдэг нэр томъёо.
47	<b>Duration хөрөнгийн хүүний мэдрэмж</b> –	A measure of interest rate risk on the sensitivity of the value of an asset to changes in interest rates.	Зээлийн хүүгийн өөрчлөлтөд хөрөнгийн үнэ цэнэ хэр мэдрэг байгааг харуулдаг хүүгийн эрсдлийг хэмжих хэмжүүр.
48	<b>Economic capital – эдийн засгийн хөрөнгө</b>	The capital needed by the insurer to satisfy its risk tolerance and support its business plans and which is determined from an economic assessment of the insurer's risks, the relationship between them and the risk mitigation in place.	Даатгагчийн эрсдлийн эдийн засгийн үнэлгээ, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал болон эрсдэл бууруулах үйл ажиллагаагаар тодорхойлогддог, даатгагчийн бизнес төлөвлөгөөг дэмжиж, эрсдэл даах чадварт тохирохуйц хэмжээний даатгагчийн хэрэгцээт хөрөнгө.
49	<b>Effect horizon-нөлөөллийн хугацаа</b>	The period over which the shock that is applied to a risk will impact the insurer. [Related definition: <i>Shock period</i> ]	Эрсдлийн улмаас даатгагчид үүссэн цочрол /шок/-ын үргэлжлэх хугацаа  Холбоотой нэр томъёо: Цочрол/шок/-ын үе
50	<b>Enterprise Risk Management (ERM) – байгууллагын эрсдлийн</b>	The process and activities of identifying, assessing, measuring, monitoring, controlling and mitigating risks in respect of the insurer's enterprise as a whole.	Даатгалын байгууллагын түвшинд эрсдлийг тодорхойлох, үнэлэх, хэмжих, шалгах, хянах болон бууруулах үйл ажиллагаа.

	<b>удирдлага</b>		
51	<b>Excess per risk reinsurance – эрсдэл тухай бүрээс давсан давхар даатгал</b>	This reinsurance method provides indemnification to the ceding company for each covered risk up to a predetermined limit. The ceding company is required to meet the obligations of the claim up to a preset dollar amount before the reinsurer becomes liable.	Эрсдэл бүр дэх босгоос давсан хэсгийн давхар даатгал Энэ аргын дагуу давхар даатгагч нь урьдчилан тогтоосон хязгаарт багтаан эрсдэл тус бүрээр давхар даатгуулагчид даатгалын нөхөн төлбөр олгодог. Давхар даатгагчийн хариуцлагаас өмнө давхар даатгуулагч нь нэхэмжлэлийн урьдчилан тогтоосон хязгаарт багтаан нэхэмжлэлийн тодорхой хэсгийг хариуцна.
52	<b>Expense ratio – зардлын харьцаа</b>	The ratio of expenses to earned premiums.	Зардлыг орлогод тооцсон хураамжид харьцуулсан харьцаа
53	<b>Facultative obligatory reinsurance – Факультатив заавал давхар даатгал</b>	An arrangement (also known as "open cover") pursuant to which the cedant may, at its option, cede certain defined risks to the reinsurer, which the reinsurer must assume, subject to the cedant's retention. This arrangement has both treaty and facultative elements. It is normally used to provide cover for risks that are irregular in incidence or to supplement a treaty that has limited capacity.	Эрсдлээ шилжүүлж буй даатгагч өөрийн сонголтоор тодорхой эрсдлийг давхар даатгагчид шилжүүлэх, давхар даатгагч даатгагчийн өөртөө авч үлдэж буй хариуцлагыг харгалзан заавал хүлээн авах хэлэлцээр. Үүнийг заримдаа "нээлттэй гэрээ" гэж нэрлэдэг. Энэ нь "гэрээний" болон "факультатив" даатгалын шинжүүдийг агуулсан байдаг. Үүнийг ихэвчлэн хэвийн бүс эрсдэл дээр, эсхүл хязгаарлагдмал хамгаалалттай гэрээний давхар даатгалд нэмэлт болгон хэрэглэдэг.
54	<b>Facultative reinsurance – Факультатив давхар даатгал</b>	Not obligatory with respect to either the cedant or the reinsurer. Facultative reinsurance involves the reinsurance of the exposures covered by a single policy, or sometimes only specific portions of a policy.	Даатгагч эрсдлээ заавал шилжүүлэх, эсхүл давхар даатгагч нь эрсдлийг заавал хүлээн авах үүрэг хүлээхгүй.  Факультатив давхар даатгалд даатгалын гэрээг дангаар нь, эсхүл тухайн гэрээний тодорхой хэсэгт хамаарах эрсдлийг хамруулна.
55	<b>Feedback loop- эргэх холбооны цагираг</b>	The process of assessing the effect, within the ERM framework, of changes in risk leading to changes in risk management policy, tolerance limits and risk mitigating actions.	Байгууллагын эрсдлийн удирдлагын хүрээнд эрсдлийг бууруулах ажиллагаа, эрсдэл даах чадварын хязгаар болон эрсдлийн удирдлагын өөрчлөлтийн нөлөөллийг тогтоох үйл явц
56	<b>Financial conglomerate- санхүүгийн нэгдэл</b>	Refers to any group of companies under common control whose exclusive or predominant activities consist of providing significant services in at least two different financial sectors (eg. banking, securities, insurance).	Санхүүгийн хоёр буюу түүнээс дээш салбарт /банк, үнэт цаас, даатгал гэх мэт/ дагнасан, эсхүл давамгайлсан үйл ажиллагаа явуулдаг, нэгдсэн хяналт бүхий бүлэг компанийг хэлнэ.
57	<b>Financial health – Санхүүгийн эрүүл байдал</b>	see <b>Solvency</b>	"Төлбөрийн чадвар"-ыг харна уу
58	<b>Financial reports – санхүүгийн тайлан</b>	Refers to both "general purpose financial reports" and "supervisory financial reports". (See separate definitions.)	Санхүүгийн ба зохицуулалтын тайлангуудыг хэлнэ.
59	<b>Finite reinsurance – Хязгаарлагдмал давхар даатгал</b>	Also known in some jurisdictions as financial reinsurance, structured reinsurance, non-traditional reinsurance, loss mitigation reinsurance. A generic term that is used to describe an entire spectrum of reinsurance arrangements that share limited risk for a limited amount of premium. In some jurisdictions finite reinsurance is a specialised form of limited liability reinsurance whereby the financial and strategic motivations of the reinsured to effect the transaction take precedence over the insurance risk transfer	Зарим оронд Санхүүгийн давхар даатгал, Бүтэц бүхий давхар даатгал, Уламжлалт бус давхар даатгал, Алдагдал бууруулах давхар даатгал гэж нэрлэдэг.  Энэ нэр томъёог тодорхой хэмжээний хураамжаар тодорхой хязгаар бүхий эрсдлийг хувааж хариуцах давхар даатгалыг бүхэлд нь илэрхийлэхэд ашигладаг.  Зарим оронд үүнийг хязгаарлагдмал хариуцлага бүхий давхар даатгалын тусгай нэг төрөл гэж үздэг бөгөөд давхар даатгуулагчийн санхүүгийн болон стратегийн сонирхол нь



		<p>motivation.</p> <p>Although there is no accepted global definition of "finite reinsurance," a typical transaction may include, but not be limited to provisions for aggregating risk, for aggregating limits of liability, for aligning the interests of the insurer and reinsurer, and for explicitly recognising the time value of money.</p> <p>A detailed review of the entire reinsurance contract and any side agreements is necessary to determine if contracts containing such clauses do transfer risk and are in fact reinsurance contracts when considered in their totality.</p>	<p>даатгалын эрсдлийг тараан шилжүүлэх сонирхлоос илүү чухалд тооцогддог.</p> <p>Хязгаарлагдмал давхар даатгалын дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тайлбар байхгүй боловч ерөнхийдөө эрсдлийг нэгтгэх, хариуцлагын хэмжээг нэгтгэх, даатгагч болон давхар даатгагчийн ашиг сонирхлыг нийцүүлэх, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тодорхой заах гэх мэт нөхцөлүүд орж болдог.</p> <p>Давхар даатгалын гэрээ болон түүний дагалдах хэлэлцээрүүдийг нарийн хянаж, эрсдлийг шилжүүлж байгаа эсэх, бүхэлдээ давхар даатгалын гэрээ гэж тооцогдох эсэхийг тодорхойлох шаардлагатай.</p>
60	<b>Four eyes principle – Дөрвөн нүдний зарчим</b>	The principle describing the involvement of more than one person in decision-making or other material activities for reasons such as validation, good governance, transparency and control".	Сайн засаглал, ил тод байдал, хяналт, хүчин төгөлдөр байдал гэх мэт асуудлаар шийдвэр гаргах, эсхүл бусад чухал үйл ажиллагаанд нэгээс олон хүн оролцох зарчим
61	<b>Fraud – Хууран мэхлэх</b>	A deceptive act or omission intended to gain advantage for a party committing the fraud (the fraudster) or for other parties.	Өөртөө давуу байдал олж авахын тулд бусдыг хууран мэхлэх үйлдэл
62	<b>Fronting arrangements – Фронтинг хэлэлцээр</b>	<p>Fronting is a term that describes a particular form of reinsurance frequently employed by captive insurers.</p> <p>Commonly, a commercial insurer licensed in the jurisdiction from which the risk emanates issues a policy to the insured. Subsequently, the risk is transferred to a captive insurance company by way of a reinsurance contract also known as a fronting agreement.</p> <p>The insured receives a policy written by the licensed commercial insurer, but the economic risk of that policy resides in the captive insurance company, although the ultimate liability remains with the fronting insurer.</p> <p>In some jurisdictions, it is a legal requirement for either all, or certain classes' of business, to be written by a local insurer. Hence, if the captive is established in a domicile other than that where the risk resides, then fronting arrangements are mandatory.</p>	<p>Каптив даатгагчдын өргөн хэрэглэгддэг давхар даатгалын төрөл.</p> <p>Тухайн улсын хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан арилжааны даатгагч даатгуулагчтай гэрээ байгуулж, харин эрсдлийг давхар даатгалын гэрээ нэрийн дор каптив даатгалын компани руу шилжүүлдэг. Үүнийг "фронтинг хэлэлцээр" гэдэг.</p> <p>Энэ тохиолдолд фронтинг хийж буй даатгагч тухайн гэрээний эцсийн хариуцлагыг хүлээх боловч уг гэрээний эдийн засгийн эрсдлийг каптив даатгагч хариуцна.</p> <p>Зарим орны хуулиар, даатгалын бүх төрлөөр, эсхүл тодорхой төрлөөр дотоодын даатгалын компанид даатгуулахыг шаарддаг.</p> <p>Эрсдэл оршин байгаа улсаас өөр улсад каптив даатгалын компани байгаа нөхцөлд фронтинг хэлэлцээр хийгддэг.</p>
63	<b>General purpose financial reports- Ерөнхий зорилгын санхүүгийн тайлан</b>	Financial reports prepared according to generally accepted accounting principles within the relevant jurisdiction to meet the common financial information needs of a wide range of users including policyholders and investors.	Даатгалын гэрээ эзэмшигчид, хөрөнгө оруулагчид гэх мэт этгээдийг санхүүгийн ерөнхий мэдээллээр хангадаг, холбогдох хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан.
64	<b>Going-concern basis- Тасралтгүй суурь</b>	A method of considering the financial situation assuming that the company will continue to operate and that future business will be written.	Тухайн компанийг үйл ажиллагаагаа цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжтой гэж тооцон санхүүгийн байдлыг авч үзэх арга зүй
65	<b>Going-concern capital- тасралтгүй сууриар тооцсон хөрөнгө</b>	Capital which achieves both the objectives of reducing the probability of insolvency by absorbing losses on a going-concern basis, or in run-off, and of reducing the loss to policyholders in the event of insolvency or winding-up.	Тасралтгүй суурь дахь алдагдлыг олж төлбөрийн чадваргүй байдлын магадлалыг багасгах, компанийг татан буулгах, эсхүл дампуурлын үед даатгалын гэрээ эзэмшигчдийн хохирлыг багасгах зорилгоор тооцсон хөрөнгө

66	<b>Group-wide internal models- группын хэмжээний дотоод загварууд</b>	<p>A risk measurement system a group uses to analyze and quantify risks to the group as a whole as well as risks to the various parts of the group, to determine the capital resources needed to cover those risks and to allocate capital resources across the group.</p> <p>Group-wide internal models may include partial models which capture a subset of the risks to the group and/or all the risks of a subset of the group.</p> <p>Group-wide internal models may also include combinations of models in respect of different parts of the group. An insurer's internal model may be part of a broader group-wide model rather than a standalone model.</p>	<p>Группын хэмжээнд болон группын нэгж хэсгүүдэд тулгарсан эрсдлийг задлан шинжилж дүгнэх, түүнийг даван туулахад шаардлагатай хөрөнгийн нөөцийг тодорхойлж группын хэмжээнд уг нөөцийг хуваарилахад хэрэглэдэг эрсдлийг хэмжих систем.</p> <p>Группын дотоод загварууд нь группт, эсхүл группын бүрэлдэхүүн хэсэгт тулгарсан бүх эрсдлийг илрүүлдэг хэсэгчилсэн загварыг багтаадаг.</p> <p>Группын хэмжээний дотоод загварт тухайн группт хамаардаг хэсгүүдийн загварууд хамаардаг.</p> <p>Даатгагчийн дотоод загвар нь бие даасан байхаасаа илүүтэйгээр группийн хэмжээний загварын нэг хэсэг байдаг.</p>
67	<b>Group-wide supervision- группын хэмжээний хяналт</b>	The supervisory approach to an insurance group which considers the group structure, any regulated or non-regulated entities.	Групп доторх компаниуд нь зохицуулалтын хүрээнд хамаарах, эсхүл үл хамаарахаас шалтгаалахгүйгээр даатгалын группт нийтэд нь авч үздэг хяналтын хандлага
68	<b>Group-wide supervision framework (GSF)- группын хэмжээний хяналтын хүрээ</b>	A supervisory framework for insurance groups that sets out the preconditions for group-wide supervision, group-wide regulatory requirements and group-wide supervisory review and reporting.	Нийт группын хяналтын урьдчилсан нөхцөл, зохицуулалтын шаардлагууд болон хяналтын дүгнэлт, тайланг тодорхойлдог, даатгалын группыг хянах хүрээ
69	<b>Group-wide supervisor- группын хэмжээний зохицуулалтын байгууллага</b>	The supervisor(s) responsible for promoting effective and coordinated supervision of an insurance group including coordinating the input of insurance legal entity supervisors in undertaking the supervision of an insurance group on a group-wide basis, as a supplement to insurance legal entity supervision.	Даатгалын группын удирдлагын үр ашигтай удирдан чиглүүлэх үүрэг бүхий Зохицуулалтын байгууллага.
70	<b>Head of the group (or parent)- группын толгой компани</b>	The head of the group or parent, whether regulated or non-regulated, is typically the legal entity that is at the top of the group structure and has a significant influence over the activities of the group as a whole. Often this would be a non-operating holding company but it could also be an insurance legal entity, among others.	Зохицуулалтын хүрээний, эсхүл зохицуулалтын хүрээний эсэхээс үл хамааран группын толгой компани нь группын бүтцийн дээд хэсэгт байдаг, группын үйл ажиллагаанд нөлөөлдөг хуулийн этгээд байна. Толгой компани нь ихэнхдээ үйл ажиллагаа явуулдаггүй холдинг компани байх боловч заримдаа даатгалын эрх бүхий этгээд байж болдог.
71	<b>Hedging- эрсдлийн хамгаалалт</b>	Actions taken to offset the impact of risks materializing.	Учрах эрсдлийн үр дагаврыг нөхөх зорилгоор авдаг арга хэмжээ
72	<b>Home jurisdiction- харьяалагдах улсын хууль тогтоомж</b>	The jurisdiction in which an insurer is incorporated or its head office is located, as applicable.	Даатгагч харьяалагддаг, эсхүл түүний төв оффис нь байрладаг улсын хууль.
73	<b>Home supervisor – Харьяалагдах улсын зохицуулалтын байгууллага</b>	The supervisor from the home jurisdiction. (see: home jurisdiction)	Компани харьяалагдаж буй улсын зохицуулалтын байгууллага  /"Харьяалагдах орны хууль тогтоомж" - тайлбарыг үзнэ үү./
74	<b>Host jurisdiction –</b>	Any jurisdiction other than the home jurisdiction in which an insurer conducts	Даатгагч даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа, даатгагчийн харьяалагдах улсаас

	<b>үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын хууль тогтоомж</b>	insurance activities.	бусад улсын хууль тогтоомж
75	<b>Host supervisor – үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын зохицуулалтын байгууллага</b>	Any supervisor from a jurisdiction other than the home jurisdiction. (see: host jurisdiction)	Даатгагч даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа даатгагчийн харьяалагдах улсаас бусад улсын зохицуулалтын байгууллага  /“үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын хууль тогтоомж” тайлбарыг харна уу/
76	<b>Hybrid approach- Холимог хандлага</b>	A supervisory approach to non-regulated entities which is a mix of different combinations of direct and indirect approaches for different aspects of supervision.	Зохицуулалтын хүрээний бус байгууллагыг хянах хяналтын хандлага Энэ нь зохицуулалтын олон талт, шууд болон шууд бусаар хандах хандлагын хослолууд байна.
77	<b>IAIS MmoU – Даатгалын зохицуулалтын байгууллагуудын олон улсын холбоо (ДЗБОУХ)-ны харилцан ойлголцлын олон талт санамж бичиг</b>	A formal multilateral agreement established by the IAIS for cooperation and information exchange between IAIS Members who are Signatory Authorities regarding the supervision of insurers where cross-border aspects arise.  It includes procedures for requesting and providing information on operations of insurers supervised by all Signatory Authorities having a legitimate interest. This MMoU covers all issues related to the supervision of insurers such as licensing, ongoing supervision and winding-up processes (where necessary).	Улс дамнасан аливаа асуудлаар ДЗБОУХ-ны гишүүн орнуудын хооронд мэдээлэл солилцох, хамтран ажиллах зорилгоор ДЗБОУХ- оос гаргасан албан ёсны олон талт хэлэлцээр.  Үүнд хууль ёсны ашиг сонирхол бүхий зохицуулалтын байгууллагаас даатгагчийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, мэдээллээр хангах асуудлыг багтаасан байдаг.  Энэ санамж бичигт тусгай зөвшөөрөл олгох, явцын хяналт, татан буулгах үйл явц (шаардлагатай үед) зэрэг даатгалын байгууллагыг хянах бүхий л асуудлыг тусгасан байдаг.
78	<b>IBNER provisions Учирсан боловч бүрэн мэдэгдээгүй хохирлын нөөц</b>	Incurred but not enough reported (IBNER) provisions: additional provisions for claims incurred but for which not enough has been reserved.	Хохирол учирсан боловч түүнд хангалттай хэмжээгээр нөөц байгуулаагүй нэхэмжлэлийг төлөхөд зориулсан нэмэлт нөөц
79	<b>IBNR provision Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц</b>	Incurred but not reported (IBNR) provision: provision for claims incurred but not reported by the balance-sheet date. That is, it is anticipated that there would be a number of policies that have, but for the advice of the claim to the insurer, occurred and therefore are likely to result in a liability on the insurer. The magnitude of this provision can be expected to reduce as the time since the insurance risk on the contract expired extends. The magnitude is also likely to vary depending on the type of insurance risk covered by any particular class of insurance contract.	Учирсан боловч тайлангийн хугацаанд мэдэгдээгүй нэхэмжлэлийг төлөхөд зориулсан нөөц. Энэ нь учирсан боловч даатгагчид мэдэгдээгүй, даатгагчийн хариуцлагад нөлөөлж болох олон тооны гэрээ байж болно гэсэн төсөөлөлд үндэслэгддэг. Энэ нөөцийн хэмжээ нь даатгалын гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш хугацаа өнгөрөх тусам буурна. Тодорхой төрлийн даатгалын гэрээгээр хамгаалагдсан даатгалын эрсдлийн хэлбэрээс учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн хэмжээ хамаарч болно.
80	<b>Indirect approach – шууд бус хандлага</b>	A supervisory approach to non-regulated entities which relies on exercise of supervisory powers through a regulated entity in the group.	Групп доторх зохицуулалтын хүрээний байгууллагаар дамжуулан хяналтын эрх мэдэлд тулгуурлан зохицуулагдаагүй байгууллагуудыг хянах хандлага.

81	<b>Indemnity reinsurance agreement</b> <b>Нөхөн төлбөрийн нөхцөл бүхий давхар даатгал</b>	The ceding entity remains legally responsible for all policyholder obligations of the reinsured policies. The assuming entity indemnifies, or protects, the ceding entity against one or more of the risks in the reinsured policies.	Давхар даатгагдаж буй гэрээний хувьд давхар даатгуулагч нь даатгуулагч бүрийн өмнө хуулийн хариуцлага хүлээдэг. Давхар даатгагч нь нэг ба түүнээс дээш эрсдлийн хувьд давхар даатгуулагчийг хамгаалдаг.
82	<b>Insurance group – Даатгалын групп</b>	A group is considered to be an insurance group for the purpose of group-wide supervision if there are two or more entities of which at least one is an insurer and one has significant influence on the insurer.  The significance of influence is determined based on criteria such as (direct or indirect) participation, influence and/or other contractual obligations; interconnectedness; risk exposure; risk concentration; risk transfer; and/or intra-group transactions and exposures.	Бүрэлдэхүүнд нь даатгагч болон түүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг компани багтсан, 2 ба түүнээс дээш тооны хуулийн этгээд оролцсон, группын хэмжээнд хяналт зохицуулалт хийх зорилгоор даатгалын групп гэж тодорхойлогдсон компанийн нэгдэл.  Мэдэгдэхүйц нөлөө нь шууд ба шууд бус оролцоо, аливаа гэрээний үүргээр холбогдсон байдал, харилцан хамаарал бүхий, эрсдэлд өртөх байдал, эрсдлийн төвлөрөлт, эрсдлийг шилжүүлэх болон групп доторх хоорондын тооцоо зэрэг хэмжүүрээр тодорхойлогдоно.
83	<b>Insurance intermediary – Даатгалын зуучлагч</b>	Any natural person or legal entity that engages in insurance intermediation.	Даатгалын зуучлалд оролцож буй хувь хүн, хуулийн этгээд
84	<b>Insurance intermediation – Даатгалын зуучлал</b>	The activity of soliciting, negotiating or selling insurance contracts through any medium <sup>1</sup> . Where:• "Solicit" means attempting to sell insurance or asking or urging a person to apply for a particular kind of insurance from a particular company for compensation. • "Negotiate" means the act of conferring directly with, or offering advice directly to, a purchaser or prospective purchaser of a particular contract of insurance concerning any of the substantive benefits, terms or conditions of the contract, provided that the person engaged in that act either sells insurance or obtains insurance from insurers for purchasers. • "Sell" means to exchange a contract of insurance by any means, for money or its equivalent, on behalf of an insurance company. In some jurisdictions certain supplemental functions are included in the definition of intermediation.	Дундын зуучлалаар дамжуулан даатгалын гэрээг ухуулах, хэлэлцэх, борлуулах дараахь үйл ажиллагааг ойлгоно: "Ухуулах" гэж даатгал борлуулах зорилгоор даатгалын ашиг тусыг ойлгуулах замаар даатгалд хамрагдахыг санал болгох, үгэндээ оруулах/итгүүлэх;  "хэлэлцэх" гэж даатгалын гэрээ борлуулж байгаа этгээд нь худалдан авагч болон боломжит хэрэглэгчтэй тухайн даатгалын гэрээний бодит давуу тал, нөхөн төлбөр, гэрээний нөхцөлийн талаар харилцан тохиролцох, зөвлөгөө өгөх;  "Борлуулах" гэж даатгалын компанийн өмнөөс даатгалын гэрээг худалдах.
85	<b>Insurance legal entity – даатгалын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд</b>	Denotes either a stand-alone insurer or an insurer which is a member of an insurance group.	Биеэ даасан нэг даатгагч, эсхүл даатгалын группын гишүүн даатгагч
86	<b>Insurance risk – даатгалын эрсдэл</b>	see Technical risks	"Техник эрсдэл" тайлбарыг харна уу
87	<b>Interest rate risk – хүүгийн эрсдэл</b>	The risk of exposure to losses resulting from movements in interest rates.	Хүүгийн өөрчлөлтийн улмаас хохиролд өртөх эрсдэл
88	<b>Internal controls – дотоод хяналт</b>	The various operational procedures by which an insurer maintains compliance with Board and management policies.	Менежментийн бодлого, ТУЗ-ын шийдвэрийн дагуу хэрэгжүүлдэг даатгагчийн үйл ажиллагааны төрлүүд

		Such procedures include the regular reporting of key financial statistics, the adherence to tolerance limits, and the use of feedback loops. The internal controls should address checks and balances such as cross checking, dual control of assets and double signatures.	Үүнд санхүүгийн гол статистик мэдээллийг тогтмол тайлагнах, эрсдэл даах чадварын хязгаарыг дагаж мөрдөх, эргэх холбооны хэрэглээ зэрэг орно.  Дотоод хяналтын үйл ажиллагаа нь хөрөнгийн давхар хяналт, нэмэлт шалгалт, давхар гарын үсгийн шалгалт болон тайлан баланст анхаарал хандуулдаг.
89	<b>Internal models – дотоод загвар</b>	The model which an insurer uses to calculate its regulatory capital which appropriately reflects its risk profile, based on accurate and appropriate data and adequate actuarial and statistical techniques that are commensurate with the nature, scale and complexity of its business.	Зохицуулах байгууллагаас шаардаж буй хөрөнгийг тооцоолоход даатгагчийн ашигладаг загвар.  Энэ нь даатгагчийн бизнесийн шинж байдал, хэмжээ болон онцлогт тохирсон, актуар тооцоолол, статистик аргачлал, тоон мэдээлэл дээр үндэслэсэн, эрсдлийн шинжилгээг тусган харуулсан байна.
90	<b>Investment management – хөрөнгө оруулалтын удирдлага</b>	The process of managing an insurer's investment portfolio given its investment strategies and risk tolerances. [Related definitions; <i>Investment policy, Investment risk management, Investment risks, Investment strategy, Investment risk exposures.</i> ]	Даатгагчийн хөрөнгө оруулалтын багцыг хөрөнгө оруулалтын стратеги болон эрсдлийг даах чадварт тохируулан удирдах үйл явц  / Холбоотой нэр томъёо:-Хөрөнгө оруулалтын бодлого, Хөрөнгө оруулалтын эрсдлийн удирдлага, Хөрөнгө оруулалтын эрсдлүүд, Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын эрсдлийн нөлөөлөл/
91	<b>Investment policy – хөрөнгө оруулалтын бодлого</b>	An insurer's policy with respect to the overall characteristics for an investment characteristics or for the investments of the insurer as a whole.	Хөрөнгө оруулалтыг бүхэлд нь авч үзсэн даатгагчийн хөрөнгө оруулалтын бодлого.
92	<b>Investment risk management – хөрөнгө оруулалтын эрсдлийн удирдлага</b>	The process an insurer uses to identify investment risk exposures, and to monitor, measure, report, and mitigate this risk.	Даатгагчийн хөрөнгө оруулалтын эрсдлийн нөлөөллийг тодорхойлох, хянах, хэмжих, тайлагнах болон уг эрсдлийг багасгах зэрэгт ашигладаг үйл явц
93	<b>Investment risks – хөрөнгө оруулалтын эрсдэл</b>	The various kinds of risk which are directly or indirectly associated with the insurers' investment policy and management. (These are usually categorised as market risk, credit risk, liquidity risk, operational risk.)	Даатгагчийн хөрөнгө оруулалтын болон удирдлагын бодлоготой шууд ба шууд бусаар холбогдон гардаг эрсдэл. Энэ нь зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл гэх мэт ангилагддаг.
94	<b>Investment strategy – хөрөнгө оруулалтын стратеги</b>	The overall direction by the insurer's investment management which governs and implements the insurer's investment policy and investment risk management policy.	Хөрөнгө оруулалтын болон хөрөнгө оруулалтын эрсдлийн удирдлагын бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхээр Даатгагчийн гаргасан ерөнхий чиглэл
95	<b>Investment risk exposures – хөрөнгө оруулалтын эрсдэлд өртөх байдал</b>	Measures of the amounts by which an insurer's financial position may vary adversely as a result of its investment policy and management.	Даатгагчийн хөрөнгө оруулалтын бодлого болон удирдлагын үр дүнгээс шалтгаалан даатгагчийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг хэмжих хэмжээ
96	<b>Involved supervisors- холбогдох хяналтын байгууллагууд</b>	Supervisors engaged in the supervision of an insurance group. Depending on the circumstances of the particular insurance group and the jurisdictions in which it operates, it could include all supervisors engaged in the supervision of entities within the insurance group.	Даатгалын группийн хяналт шалгалтыг хийж байгаа хяналтын байгууллагууд. Тухайн даатгалын группын нөхцөл байдал болон харьяалагдах хуулиас хамааран даатгалын групп доторх байгууллагуудын хяналтыг хийдэг бүх хяналтын байгууллагууд багтдаг.
97	<b>Key</b>	Individuals defined by legislation, such as	Зохих шаардлага хангасан, хууль журмаар



	<b>functionaries- эрх бүхий албан тушаалтан</b>	board members and senior management, who must meet suitability requirements. The key functionaries identified may differ depending on the legal form and governance structure.	тусгайлан заасан ТУЗ-ын гишүүд, удирдах ажилтнууд зэрэг хувь хүмүүс байна. Эрх бүхий албан тушаалтан нь хуулийн этгээдийн хэлбэр, засаглалын бүтэц зэргээс хамааран өөр өөр байж болно.
98	<b>Key persons in control functions- хяналтын эрх бүхий албан тушаалтан</b>	Persons responsible for control functions. [See <i>Control functions</i> ]	Хяналт тавих үүрэг бүхий ажилтнууд.  "Хяналтын үүрэг"-тайлбарыг үзнэ үү.
99	<b>Leverage – хөшүүрэг</b>	The ability to influence a system in a way that multiplies the outcome of one's efforts without a corresponding increase in the consumption of resources.  This implies that leverage is the advantageous condition of having a relatively small amount of cost, which could yield a relatively high level of returns. "Financial leverage" refers to the use of borrowed money to increase the production volume and thus the net earnings. It is measured as the ratio of total debt to total assets. The greater the amount of debt, the greater the financial leverage.	Эх үүсвэрийг өсгөлгүйгээр үр дүнг нэмэгдүүлэх замаар системд нөлөөлөх чадвар.  Хөшүүрэг гэдэг нь харьцангуй бага зардлаар давуу нөхцөл олж авах, харьцангуй өндөр ашиг олох гэсэн санаа агуулдаг.  "Санхүүгийн хөшүүрэг" нь зээлийн хөрөнгийг ашиглан бүтээгдэхүүний тоо хэмжээ, түүнтэй уялдан цэвэр ашгийг өсгөх гэж тайлбарлаж болно.  Үүнийг нийт өр төлбөрийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаагаар хэмждэг. Өр төлбөрийн дүн их байх тусам санхүүгийн хөшүүрэг тэр хэмжээгээр их байна.
100	<b>Licensing – тусгай зөвшөөрөл олгох</b>	The formal authority given to an entity to conduct insurance activities under the applicable insurance legislation.	Даатгалын хууль болон холбогдох журмын дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөл олгох
101	<b>Liquidity risk – хөрвөх чадварын эрсдэл</b>	The risk that an insurer is unable to realise its investments and other assets in a timely manner in order to settle its financial obligations as they fall due.	Даатгагч санхүүгийн үүргээ хугацаанд нь биелүүлэхэд шаардагдах хөрөнгө болон хөрөнгө оруулалтаа зөв удирдаж чадаагүйгээс үүсэх эрсдэл
102	<b>Loss ratio (claims ratio) – хохирлын харьцаа /нэхэмжлэлийн харьцаа/</b>	The ratio of claims incurred to earned premiums. Gives an indication of how well the pricing of an insurer matches the risks taken in the insurance contracts. [Related definitions: <i>Claims incurred, Underwriting year basis</i> ]	Учирсан хохирлыг орлогод тооцсон хураамжид харьцуулсан харьцаа.  Энэ харьцаа нь даатгалын хураамжийн тооцоолол нь гэрээний дагуу хүлээх үүрэгтэй хэрхэн уялдаж байгааг харуулдаг.  [Холбоотой нэр томъёо: <i>учирсан хохирол, андеррайтенгийн жилд суурилсан</i> ]
103	<b>Margin over current estimate- (MOCE)- одоогийн үнэлгээнээс давсан хэсэг /зөрүү</b>	A margin that exceeds the Current Estimate in valuation of technical provisions to cover the inherent uncertainty of those obligations. [Related definitions: <i>Current Estimate, Technical provision.</i> ]	Гэрээгээр хүлээсэн үүргээ хангаж чадахуйц техникийн нөөцийн одоогийн үнэлгээнээс давсан хэсэг буюу зөрүү [Холбоотой нэр томъёо: <i>Одоогийн үнэлгээ, Техникийн нөөц.</i> ]
104	<b>Market-consistent valuation- зах зээлд нийцүүлсэн үнэлгээ</b>	An economic valuation of an insurer's assets and liabilities that is consistent with either the assessment of their risk and value by market consistent ("mark-to-market" valuation) or, in the absence of a direct market evaluation, the valuation principles, methodologies and risk parameters that market participants would expect to be used ("mark-to-model" valuation).	Эрсдлийн үнэлгээ ба зах зээлийн үнэтэй уялдсан ("mark-to-market" үнэлгээ), эсхүл шууд зах зээлийн үнэлгээ байхгүй тохиолдолд зах зээлд оролцогчид ашиглах үнэлгээний зарчмууд, арга зүйн болон эрсдлийн параметр ("mark-to-model" үнэлгээ) тай уялдсан, даатгагчийн хөрөнгө, эх үүсвэрүүдийн эдийн засгийн үнэлгээ.

105	<b>Market risk – зах зээлийн эрсдэл</b>	The risk to an insurer's financial condition arising from movements in the level or volatility of market prices of assets, liabilities and financial instruments, whether on all investments as a whole (general market risk) or on an individual investment (specific market risk).	Нийт хөрөнгө оруулалтад, (зах зээлийн ерөнхий эрсдэл), эсхүл тухайлсан хөрөнгө оруулалтад (зах зээлийн тусгай эрсдэл) нөлөөлөх замаар хөрөнгө, хариуцлага, санхүүгийн хэрэгслүүдийн зах зээлийн үнийн түвшин, хувирамтгай байдлын өөрчлөлтөөс үүдэн даатгагчийн санхүүгийн байдалд нөлөөлөх эрсдэл.
106	<b>Memorandum of understanding – харилцан ойлголцлын санамж бичиг</b>	A formal agreement between supervisory authorities which includes compliance with a strict confidentiality regime. In such agreements, the parties acknowledge that each may only provide information under the agreement to the extent permitted or not otherwise prevented under their respective jurisdictional laws, regulations and requirements.	Хяналтын эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан нууцлалыг чанд хадгалах нөхцөл бүхий албан ёсны хэлэлцээр. Үүнд тус тусын эрх мэдэл хэрэгжиж буй бүс нутгийн хууль, дүрмээр зөвшөөрөгдсөн хэмжээнд, зөвхөн гэрээнд заасан мэдээллээр хангахаас өөрөөр бие биедээ саад хийхгүй байхаар талууд харилцан тохиролцсон байдаг.
107	<b>Minimum Capital Requirement (MCR) – заавал байх хөрөнгийн доод хэмжээ</b>	In the context of a legal entity's capital adequacy assessment, the level of solvency at which, if breached, the supervisor would invoke its strongest actions, in the absence of appropriate corrective action by the insurer.	Хуулийн этгээдийн хөрөнгийн зохистой байдлын үнэлгээний хүрээнд тогтоодог төлбөрийн чадварын түвшин. Даатгагч төлбөрийн чадварын энэ түвшинг хангаагүй бөгөөд хангах арга хэмжээ аваагүй тохиолдолд зохицуулах байгууллагаас албадлагын хатуу арга хэмжээг авдаг.
108	<b>Mismatching risk Үл нийцэх эрсдэл</b>	The risk emerging when the future cash flows generated by assets do not coincide with (or do not cover) the cash flow demands of the corresponding liabilities in a suitable manner. (This would include Currency Risk).	Актив хөрөнгөөр бий болох ирээдүйн мөнгөн урсгал нь даатгагчийн хүлээх хариуцлагын мөнгөн урсгалын хэрэгцээтэй тохирохгүй (хааж чадахгүй) байх эрсдэл (үүнд ханшийн эрсдэл орно)
109	<b>Modified coinsurance basis – хамтын даатгалын шинэчилсэн хэлбэрт суурилсан</b>	Modified coinsurance, or 'modco', differs from coinsurance and coinsurance with funds withheld agreements, in that the portion of policy assets and reserves normally entitled to the reinsurer are actually retained by the ceding company. In addition to the transactions required in a coinsurance arrangement, a "reserve adjustment" must be calculated. For each accounting period, the change in reserves is first determined. If these have increased, the amount of the increase, less interest on the reserve for the period, if positive, will be payable to the ceding company. If negative, the amount of the decrease, plus interest on the reserve, will be payable by the cedant to the reinsurer. The rationale for this procedure is that the ceding company holds the policy reserves and the corresponding assets on the reinsured business and, therefore, is responsible for the portion of the reserve increase derived from interest on the policy assets. Any other fluctuations in the reserve would be the responsibility of the reinsurer. Establishing the reserve adjustment interest rate is a complex part of the treaty negotiations. The formula for calculating the interest rate is typically set forth in the reinsurance agreement.	Засварласан хамтын даатгал буюу "modco" нь давхар даатгагчийн хариуцсан хэсэгт ногдох даатгалын гэрээний хураамж болон нөөцийг давхар даатгуулагч авч үлддэгээрээ хамтын даатгал болон суутгал хийсэн хамтын даатгалаас ялгаатай.  Хамтын даатгалын хэлэлцээрт хийгддэг гүйлгээнүүдээс гадна "нөөцийн тохируулга"-ыг тооцоолох шаардлагатай.  Тайлант хугацаа бүрт нөөцийн өөрчлөлтийг хамгийн түрүүнд тодорхойлдог.  Нөөцийн хэмжээ өссөн бол өссөн дүнгээс нөөцийн сангийн тухайн хугацааны хүүг хасч, хассан дүн эерэг гарч байвал түүнийг давхар даатгуулагчид төлдөг.  Хэрэв сөрөг гарч байвал бүүрсан дүн дээр нөөцийн сангийн хүүг нэмж давхар даатгуулагч нь давхар даатгагчид төлнө.  Энэ нь давхар даатгуулагч давхар даатгалын гэрээний нөөц ба түүнтэй адилтгах бусад хөрөнгийг өөрийн мэдэлд байлгадаг тул гэрээнд заасан хөрөнгийн хүүгээс бий болсон нөөцийн өсөлтөд хариуцлага хүлээдэгтэй холбоотой.  Нөөцийн бусад өөрчлөлтүүдийг давхар даатгагч хариуцна.  Нөөцийн тохируулга хийх хүүгийн түвшинг тогтоох нь гэрээ хэлбэрийн давхар даатгалын

			хэлэлцээний нарийн төвөгтэй хэсэг байдаг бөгөөд хүүг тооцоолох томъёог гэрээнд тусгаж өгдөг.
110	<b>Money laundering – мөнгө угаах</b>	The processing of the proceeds of crime to disguise their illegal origin.	Гэмт хэргийн замаар олсон орлогоо хууль бус болохыг нуун далдлах зорилгоор гүйлгээнд оруулах үйл явц
111	<b>Multiple gearing-Олон талт тохируулга</b>	Arises where the same capital is used simultaneously as a buffer against risk in two or more regulated entities.	Зохицуулалтын хүрээний хоёр ба түүнээс дээш хуулийн этгээдийн эрсдлийг хаах зорилгоор хөрөнгийг давхардуулан ашиглах
112	<b>Non-regulated entities- зохицуулалтын хүрээний бус байгууллагууд/</b>	Either non-operating holding companies (NOHCs) or operating entities which are not subject to any form of direct prudential supervision (non-regulated operating entities or NROEs).	Зохицуулалтын хүрээнд хамаардаггүй үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд болон үйл ажиллагаа гардан явуулдаггүй холдинг компаниуд.
113	<b>Operating ratio – үйл ажиллагааны харьцаа</b>	The combined ratio adjusted by the addition of allocated investment return to earned premiums.	Орлогод тооцсон хураамж дээр хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмж тохируулсан хосолсон харьцаа
114	<b>Operational risk – үйл ажиллагааны эрсдэл</b>	The risk arising from the inadequacy or failure of internal systems, personnel, procedures or controls leading to financial loss. Operational risk also includes custody risk.	Тухайн байгууллагын дотоод тогтолцоо, боловсон хүчин, дүрэм, журам болон хяналт хангалтгүй, эсхүл алдаатай байсны улмаас санхүүгийн хохирол учруулж болох эрсдэл.  Үйл ажиллагааны эрсдэлд хадгалалт, хамгаалалтын эрсдэл багтдаг.
115	<b>Option – опшин /опцион/</b>	The contractual right, but not the obligation, to buy or sell a specified amount of a given financial instrument, asset or liability, at a fixed price before or at a designated future date. A call option involves the right to buy the financial instrument. A put option involves the right to sell the financial instrument.	Ирээдүйд тогтсон хугацааны эцэст, эсхүл түүнээс өмнө, тогтсон үнээр, тусгайлан заасан хэмжээгээр тодорхой санхүүгийн хэрэгсэл, хөрөнгө, эсхүл өр төлбөрийг худалдах, худалдан авах үүргийн бус гэрээний эрх Коол опшин /call option/ нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах эрх. Пүт опшин /put option/ нь санхүүгийн хэрэгслийг худалдах эрх.
116	<b>Outsourcing - аутсорсинг</b>	An arrangement of any form between an entity and a service provider by which that service provider performs a process, a service or an activity which would otherwise be undertaken by the entity itself.	Тухайн байгууллага өөрийн зарим ажил, үйлчилгээ, үйл ажиллагаагаа тухайн чиглэлээр мэргэшсэн, үйлчилгээ үзүүлэгч өөр байгууллагаар гүйцэтгүүлэхээр тохиролцсон хэлцэл
117	<b>Per occurrence (catastrophe) excess of loss – тохиолдол бүрийн (гамшиг) босгоос давсан хэсгийн давхар даатгал</b>	This reinsurance method is identical to the 'Excess per Risk of Reinsurance', except that the policies are designed to account for an accumulation of losses from a single catastrophic event.  As catastrophic events can result in significant losses, the insurer may find it necessary to cede parts of the risk to different reinsurers, or the assuming reinsurer may cede some of the assumed risk to others (retrocession). In non-proportional reinsurance the reinsurer does not assume responsibility for a proportional share of all losses. Therefore the distribution of premium will not be on a proportional basis. Non-proportional reinsurance is commonly	Энэ давхар даатгалын арга нь "эрсдэл бүрээс давсан давхар даатгал"-тай ижил бөгөөд нэг удаагийн гамшигийн шинжтэй тохиолдлын улмаас үүссэн бүх хохирлыг төлөх зорилгоор гэрээ хийдгээрээ онцлогтой.  Гамшигийн улмаас их хэмжээний хохирол учирч болох тул даатгагч эрсдлийн зарим хэсгийг өөр өөр давхар даатгагчид шилжүүлэх, эсхүл эрсдлийг хүлээн авсан давхар даатгагч нь уг эрсдлийг дахин давхар даатгуулж болно. Шууд бус хамааралтай давхар даатгалаар, давхар даатгагч бүх хохиролд хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээдэггүй. Тиймээс хураамжийг мөн хувь тэнцүүлэн хуваарилдаггүй. Шууд бус хамааралтай давхар даатгал нь хэд хэдэн шатлалтай:

		arranged in a series of layers, the first of which attaches immediately to the excess of the insurer's retention, followed by as many additional layers as are necessary to generate the required total amount of capacity (per risk), or to afford such catastrophe (per occurrence) or aggregate (net retained loss) protection as deemed prudent and sufficient, given the size, geographic distribution and nature of the insurer's portfolio of business.	Эхний шатлал нь даатгагчийн өөртөө үлдээсэн хэсгээс давсан хэсэгт үйлчилдэг. Дараа дараагийн шатлал нь шаардлагатай хамгаалалтыг хангахуйц чадавхийг бий болгох /эрсдэл тухай бүрт/, тухайлсан гамшгийн хувьд (тохиолдол бүрд), эсхүл бүхэлд нь (өөрт үлдээсэн цэвэр хохирлын дүн) хамгаалж чадахуйц байна. Энэ нь даатгагчийн бизнесийн багцын шинж чанар, хэмжээ, газар нутгийн тархалт, хангалттай байдал зэргээс хамаарна.
118	<b>Policy liabilities</b> – <b>Гэрээний хариуцлага</b>	see <b>Technical provision</b>	"Техник нөөц" нэр томъёоны тайлбарыг харна уу.
119	<b>Premium deficiency reserve</b> <b>хураамжийн хомсдлын нөөц</b>	see <b>Provision for unexpired risks</b>	"Хугацаа нь дуусаагүй эрсдлийн нөөц" нэр томъёоны тайлбарыг харна уу
120	<b>Producer owned reinsurance companies (PORCs)</b> – <b>Даатгалын зуучлагчийн эзэмшдэг давхар даатгалын компани</b>	Captives, or cells of protected cell companies, that are beneficially owned by the producers of the business that is ultimately reinsured into the company through an independent fronting insurer.  There are additional risks associated with these companies since the producer could be in a position to influence the placing of business with its own captive and could control the level of premiums or commissions that apply.	Биеэ даасан фронтинг даатгагчаар дамжуулан өөрийн эзэмшлийн компанидаа давхар даатгуулдаг, даатгалын бизнесийн зуучлагч нь эзэмшдэг каптив компаниуд, эсхүл олон салбарт үйл ажиллагаа явуулдаг нэг толгой компаниудтай компаниуд. Энд даатгалын бизнесийн зуучлагч нь өөрийн каптив компанидаа даатгуулахад нөлөөлөх, мөн хураамж болон борлуулалтын шимтгэлийн хэмжээг хянах боломжтой байдаг тул тэдгээр компаниудтай холбоотой нэмэлт эрсдэл байдаг.
121	<b>Proportional reinsurance (pro-rata)</b> – <b>Шууд хамааралтай давхар даатгал</b>	Under proportional reinsurance the insurer and the reinsurer share in an agreed ratio all premiums, losses, and loss expenses arising out of the original business covered under the reinsurance agreement.  There are two forms of proportional reinsurance in the non-life business: Quota Share and Surplus Share. As a general rule, life insurance companies establish limits of retention. These limits, which may vary by age at issue, plan, or substandard classification, are the amounts which the insurer has decided it can safely retain at its own risk for newly issued policies. A schedule of limits of retention also includes limits for supplemental benefits such as disability and accidental death. These limits may or may not be independent of the limits for life insurance benefits. With these limits of retention established for all the forms of coverage issued, an insurer makes reinsurance arrangements with one or more reinsurers to take care of those applications on which the amounts are in excess of the established retention. In life business, proportional reinsurance comprises the following: Yearly Renewable Term (YRT) or Risk Premium	Шууд хамааралтай давхар даатгалаар даатгагч болон давхар даатгагч нь хураамж, хохирол, хохирлын улмаас гарсан даатгагчийн зардал зэргийг давхар даатгалын гэрээгээр тохиролцсон хувь хэмжээгээр хувааж хариуцдаг.  Шууд хамааралтай давхар даатгал нь амьдралын бус даатгалын хувьд хувь оролцооны ба хувьсах оролцооны гэсэн 2 төрөлтэй.  Ерөнхийдөө амьдралын даатгалын компаниуд өөрт үлдээх хэмжээний хязгаарыг тогтоодог.  Эдгээр хязгаар нь гэрээ байгуулах үеийн нас, даатгалын хамгаалалтын төрөл, стандарт бус ангилал зэргээс хамаарч өөр өөр байж болно.  Хязгаар нь даатгагчийн шинээр байгуулж буй даатгалын гэрээнүүдэд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх чадварыг харуулсан дүн юм.  Өөртөө үлдээх хэмжээг харуулсан товъёог дээр хөдөлмөрийн чадвар алдалт, гэнэтийн ослоор нас баралт зэрэг нэмэлт нөхцөлүүдийн хязгаарыг оруулсан байдаг.  Эдгээр хязгаарууд нь амьдралын даатгалын нөхөн төлбөрийн хэмжээнээс хамааралтай,

		Reinsurance Basis, Coinsurance Basis, Coinsurance with Funds Withheld and Modified Coinsurance Basis.	<p>эсхүл хамааралгүй байж болно.</p> <p>Даатгагчийн байгуулж буй гэрээ тус бүрт, даатгалын хамгаалалтын төрөл бүрт хязгаар тогтоосноор даатгагч нэг ба түүнээс олон давхар даатгагчтай өөрийн хүлээсэн хариуцлагаас давсан хэсэг дээр хамгаалалт өгч чадахуйц давхар даатгалын гэрээ, тохиролцоо хийдэг.</p> <p>Амьдралын даатгалын хувьд шууд хамааралтай давхар даатгал нь жил бүр сунгагдах буюу эрсдэл тооцсон хураамж дээр суурилсан давхар даатгал, хамтын даатгал дээр суурилсан, резерв суутгал хийсэн хамтын даатгал дээр суурилсан, шинэчлэгдсэн хамтын даатгал дээр суурилагдсан давхар даатгал зэргээс бүрддэг.</p>
122	<b>Prospective cover</b> <b>Хэтийн төлөвт давхар даатгалын хамгаалалт</b>	Reinsurance cover that serves to reduce volatility in current and future premiums and claims patterns.	Одоогийн болон ирээдүйд орж ирэх хураамж болон хохирлын хэлбэлзлийг багасгах зорилгоор хийдэг давхар даатгалын хамгаалалт.
123	<b>Protected Cell Company (PCC)-</b> <b>Бие даасан хариуцлагатай нэгжүүд бүхий компани</b>	<p>A single company consisting of a core and an indefinite number of cells, which are kept legally separate from each other. Each cell has assets and liabilities attributed to it, and its assets cannot be used to meet the liabilities of any other cell. The company will also have non-cellular (core) assets, which may be available to meet liabilities that cannot be attributed to a single cell.</p> <p>A PCC can create and issue shares ('cell shares') in respect of any of its cells but the company is managed by a single Board.</p> <p>[Equivalent terms: <i>Segregated Account Company (SAC), Segregated Portfolio Company (SPC)</i>]</p>	<p>Бие биенээсээ хууль ёсоор тусгаарлагдсан, нэгжүүдээс бүрдсэн дан ганц компани. Нэгж тус бүр хөрөнгө, эх үүсвэр ба өөрт тохирсон үүрэг хариуцлагатай боловч энэ хөрөнгө, хариуцлагаараа бусад нэгжүүдийн өмнө үүрэг хариуцлага хүлээдэггүй.</p> <p>Компани нь өөрийн үүрэг хариуцлагатай тохирч байх нэгжийн бүс өөрийн хөрөнгөтэй, зөвхөн нэг ТУЗ-тай байх бөгөөд өөрийн аль ч нэгжийн хувьд хувьцаа гаргаж болно.</p> <p>[ижил утгатай нэр томъёо: <i>Segregated Account Company (SAC), Segregated Portfolio Company (SPC)</i>]</p>
124	<b>Provision for unearned premiums – орлогод тооцоогүй хураамжийн нөөц</b>	<p>Amount on the balance sheet representing that part of premiums written on unexpired policies to be allocated to the following financial year, or to subsequent financial years.</p> <p>[Equivalent term: <i>Unearned premium reserve</i>]</p> <p>[Related definition: <i>Provision for unexpired risks</i>]</p>	<p>Хугацаа дуусаагүй даатгалын гэрээний нийт хураамжийг дараа, дараагийн санхүүгийн жилд хуваарилж, тайлан баланс дээр тусгасан дүн.</p> <p>[ижил утгатай нэр томъёо: <i>орлогод тооцоогүй хураамжийн нөөц</i>]</p> <p>[Холбоотой нэр томъёо: хугацаа дуусаагүй эрсдлийн нөөц]</p>
125	<b>Provision for unexpired risks – хугацаа дуусаагүй эрсдлийн нөөц</b>	<p>Amount set aside on the balance sheet in addition to unearned premiums with respect to risks to be borne by the insurer after the end of the reporting period, in order to provide for all claims and expenses in connection with insurance contracts in force in excess of the related unearned premiums and any premiums receivable on those contracts. [Equivalent term: <i>Premium deficiency reserve</i>]</p> <p>[Related definition: <i>Provision for unearned premiums</i>]</p>	<p>Орлогод тооцоогүй хураамж дээр нэмж тайлант хугацаанаас хойш хүчин төгөлдөр үйлчилж байгаа даатгалын гэрээтэй холбогдон гарах хохирол болон зардлын орлогод тооцоогүй хураамж болон төлөгдөөгүй хураамжаас давсан хэсгийг нөхөн төлөх зорилгоор даатгагчийн хүлээх эрсдэлд зориулан хуримтлуулж буй балансад тусгагдсан мөнгөн дүн.</p> <p>[ижил утгатай нэр томъёо: <i>Хураамжийн хомсдлын нөөц</i>]</p> <p>[Холбоотой нэр томъёо: <i>Орлогод тооцоогүй</i>]</p>



			<i>хураамжийн нөөц]</i>
126	<b>Quota share reinsurance – Хувь оролцооны давхар даатгал</b>	<p>This type of reinsurance was the earliest form of proportional reinsurance and is still widely used wherever appropriate. Quote share reinsurance arrangements represent a sharing of all business in a fixed ratio, or proportion. A 50% quota share agreement is one in which premiums, losses, and loss expenses are shared equally, half being retained by the insurer and half being ceded to the reinsurer. A 70% quota share would involve a 70% share ceded to the reinsurer, with the remaining 30% retained by the insurer. The insurer's needs and objectives, and the amount of proportional capacity available in the reinsurance marketplace at the time of placement, will determine the percentage share it will retain for its own account. Quota share treaties are invariably obligatory contracts. The contract will contain a stipulated limit of liability with respect to any single original policy. There will ordinarily be certain forms of coverage or classes of business that are excluded under the terms of the contract. These may not be ceded to the reinsurer without prior review and approval (usually referred to as a special acceptance) by the reinsurer. The reinsurance premium is simply the reinsurer's proportional share of the insurer's original premium for all business ceded. The reinsurer's share of the insurer's acquisition costs and general operating expenses associated with the ceded business is recovered by the insurer via a ceding commission allowance, a deduction from the reinsurer's share of the gross original premium.</p>	<p>Энэ нь шууд хамааралтай давхар даатгалын хамгийн анхны хэлбэр бөгөөд өргөн хэрэглэгддэг.</p> <p>Энэ даатгалаар даатгагч бүх бизнесээ тогтсон хувь, харьцаагаар давхар даатгагчтай хуваан хариуцдаг.</p> <p>50%-ийн оролцоотой давхар даатгалын гэрээгээр хураамж болон хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг тэнцүү хувааж, хагас нь даатгагчид үлдэж, үлдсэн хэсгийг давхар даатгагчид шилжүүлнэ.</p> <p>70%-ийн оролцоотой давхар даатгалын гэрээгээр 70% нь давхар даатгагчид шилжиж, 30%-ийг нь даатгагч өөрийн хариуцлагад авч үлдэнэ.</p> <p>Даатгагчийн өөртөө авч үлдэх хувь хэмжээ нь тухайн даатгагчийн зорилго, хэрэгцээ болон давхар даатгалын зах зээл дээрх эрсдэл хүлээж авах чадамжаас хамаарч тодорхойлогддог.</p> <p>Хувь оролцооны давхар даатгалын гэрээ нь заавал биелүүлэх гэрээ байдаг.</p> <p>Энэхүү гэрээгээр даатгалын гэрээ тутамд хүлээх хариуцлагын дээд хэмжээг тодорхойлсон байна.</p> <p>Ерөнхийдөө зарим төрлийн хамгаалалт болон даатгалын төрлүүд энэ гэрээнд ордоггүй бөгөөд тэдгээрийг давхар даатгагчид урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авахгүйгээр давхар даатгалд шилжүүлж болдоггүй.</p> <p>Давхар даатгалын хураамж нь гэрээгээр тохиролцсон хувиар тодорхойлогддог.</p> <p>Даатгагчийн тухайн бизнесийг олж авахад гарсан зардал, үйл ажиллагааны зардлыг хуваалцах зорилгоор давхар даатгагч тодорхой хувийг давхар даатгалын борлуулалтын шимтгэл хэлбэрээр даатгагчид буцаан олгодог ба үүнийг давхар даатгалын нийт хураамжаас хасч тооцно.</p>
127	<b>Rating agency – зэрэглэл тогтоох агентлаг</b>	Entity that specializes in assigning credit ratings to borrowers.	Зээлдэгч нарт зээлийн үнэлгээ тогтоодог мэргэшсэн байгууллага.
128	<b>Regulatory capital – хуулиар шаардсан хөрөнгө</b>	Surplus of assets over liabilities, evaluated in accordance with regulation in a particular jurisdiction.	Хууль журамд заасны дагуу тооцоолсон, өр төлбөрөөс давсан хөрөнгийн хэмжээ
129	<b>Regulatory capital requirements - хуулиар шаардсан хөрөнгийн</b>	Financial requirements that are set as part of the solvency regime and relates to the determination of amounts of capital that an insurer must have in addition to its technical provisions and other liabilities.	Төлбөрийн чадварын шалгуурын хүрээнд даатгагчийн нөөц болон бусад өр төлбөрийн хэмжээнээс давсан хөрөнгийн хэмжээг тодорхойлох санхүүгийн шалгуур үзүүлэлт.

	<b>шалгуур үзүүлэлт</b>		
130	<b>Reinsurance – давхар даатгал</b>	An insurance contract between one insurer or reinsurer (the reinsurer) and another insurer (the cedant) to indemnify against losses on one or more contracts issued by the cedant in exchange for a consideration (the premium).	Даатгагч, эсхүл давхар даатгагч (давхар даатгуулагч) ба өөр давхар даатгагчийн хооронд байгуулсан гэрээ.  Даатгагч буюу давхар даатгуулагч анхны даатгуулагчийн өмнө хүлээсэн гэрээний хариуцлагаа хураамж төлсний үндсэн дээр давхар даатгагчид шилжүүлдэг.
131	<b>Reinsurer – давхар даатгагч</b>	An insurer that offers protection through the sale of a reinsurance contract to a risk-transferring policyholder who is an insurer. If the risk-transferring policyholder is a (re)insurer itself, the risk-assuming insurer is called the reinsurer, and the risk transfer is known as retrocession.	Даатгагчийн эрсдлийг хүлээн авч байгаа даатгагч. Давхар даатгагч эрсдлийг дахин шилжүүлэх үйл явцыг “дахин давхар даатгал” гэж нэрлэдэг.
132	<b>Resolution-шийдвэр</b>	Any action by an authority, with or without private sector involvement to deal with serious problems in an insurer or insurance group that imperil the viability of the insurer or the insurance group.	Даатгагч, даатгалын группын үйл ажиллагаанд үүсдэг аливаа ноцтой асуудлыг шийдвэрлэх зорилгоор эрх барих байгууллагаас шаардлагатай үед хувийн хэвшлийн оролцоотой, эсхүл оролцоогүйгээр авч байгаа арга хэмжээ
133	<b>Retakaful Такафүл давхар даатгал</b>	Reinsurance undertaken in accordance with Islamic Takaful principles. [Related definition: <i>Takaful</i> ]	Исламын Такафүл зарчмын дагуу хийгдсэн давхар даатгал [Холбоотой нэр томъёо: такафүл]
134	<b>Retrospective cover (or adverse loss contract) – буцаан үйлчлэх хамгаалалт (сөрөг нөлөөтэй хохирлын гэрээ)</b>	Reinsurance contract that provides protection against an unexpected deterioration of prior year reserves than expected.	Өмнөх жилийн нөөц сан төлөвлөж байснаас буурах тохиолдлыг хамгаалах зорилго бүхий давхар даатгалын гэрээ
135	<b>Risk appetite – Эрсдэл хүлээх сонирхол</b>	The amount of risk an insurer is willing to accept in the aggregate, relative to financial capacity to assume losses, and to align with and support its strategic and financial objectives. [Related definition: <i>Risk tolerance</i> ]	Даатгагч өөрийн санхүүгийн чадавхи, стратегийн ба санхүүгийн зорилтод тулгуурлан өөрөө үүрэх эрсдлийн нийт хэмжээ
136	<b>Risk concentration – эрсдлийн төвлөрөл</b>	An exposure with the potential to produce an accumulation of losses large enough to threaten an insurer's financial condition or ability to maintain core operations. [Related definitions: <i>Concentration risk, Contagion</i> ].	Даатгагчийн санхүүгийн байдалд, эсхүл үндсэн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх чадварт аюул учруулж болохуйц томоохон хохирлын бөөгнөрөлийг бий болгох боломжтой нөхцөл байдал [Холбоотой нэр томъёо: <i>Concentration risk, Contagion</i> ].
137	<b>Risk gap – эрсдлийн завсар</b>	A key measure of the adequacy of a captive's capital and reserves is the risk gap.  This is defined as the projected total of a captive's net retained liability less year one premiums net of expenses, capital, profit and loss account balance and any other free reserves.  Captive owners and managers are required to demonstrate how the captive manages the risk gap.  Protection strategies may include guarantees of additional capital or	Каптив компанийн хөрөнгө болон нөөцийн хангалттай эсхийг хэмжих гол хэмжүүр нь эрсдлийн завсар юм.  Үүнийг каптив компанийн тооцоолсон өөрийн хүлээх цэвэр хариуцлагын дүнгээс эхний жилийн хураамж /зардлыг хассан/, хөрөнгө, орлогын тайлангийн баланс болон бусад чөлөөт нөөцийг хассан хэмжээг хэлнэ.  Каптив даатгагчийн эзэд болон менежерүүд нь эрсдлийн завсрыг хэрхэн удирдаж байгаагаа тайлагнах шаардлагатай байдаг.

		premiums, LOCs, or other alternatives in a form acceptable to the supervisor.	Хамгаалалтын стратегид нэмэлт хөрөнгө, эсхүл хураамжийн баталгаа, итгэмжлэл болон хянан зохицуулагч байгууллагын хүлээн зөвшөөрч болох бусад хэлбэрүүд байж болно.
138	<b>Risk management – эрсдлийн удирдлага</b>	Risk management is the process whereby the insurer's management takes action to assess and control the impact of past and potential future events that could be detrimental to the insurer. These events can impact both the asset and liability sides of the insurer's balance sheet, and the insurer's cash flow.	Даатгагчид хохирол учруулж болзошгүй өнгөрсөн болон ирээдүйн үйл явдлуудын нөлөөллийг үнэлэх, хянах зорилгоор даатгагчийн удирдлагын авч хэрэгжүүлж буй процессийг эрсдлийн удирдлага гэнэ. Эдгээр үйл явдал нь даатгагчийн тайлан тэнцлийн хөрөнгө болон эх үүсвэр, мөнгөн урсгалд нөлөөлж болно.
139	<b>Risk tolerance – эрсдэл даах чадвар</b>	The term "risk tolerance" is used to include the active retention of risk that is appropriate for an insurer in the context of its strategy, financial strength, and the nature, scale and complexity of its business and risks. Risk tolerance is typically a percentage of the absolute risk bearing capacity for an insurer. [Related definition: <i>Risk appetite</i> ]	Даатгагч өөрийн стратеги, санхүүгийн чадавхи, бизнесийн болон эрсдлийн шинж чанар, хэмжээ, цар хүрээнд тохируулан эрсдлийг өөртөө идэвхтэйгээр буюу бодитойгоор авч үлдэж байгаа үед хэрэглэгддэг. Эрсдэл даах чадвар нь даатгагчийн эрсдлийг даах үнэмлэхүй чадварын хувиар илэрхийлэгддэг.  [Холбоотой нэр томъёо: <i>Эрсдэл хүлээх сонирхол</i> ]
140	<b>Scenario test – хувилбарт сорил</b>	A complicated type of test, which contains simultaneous moves in a number of risk factors and is often linked to explicit changes in the view of the world. Scenario tests often examine the impact of catastrophic events on an insurer's financial condition, particularly in a defined geographical area, or simultaneous movements in a number of risk categories affecting all of the insurer's business lines or trading operations, e.g., underwriting volumes, equity prices and interest rate movements. There are two basic types of scenarios: historical and hypothetical. Historical scenarios reflect changes in risk factors that occurred in specific historical episodes. Hypothetical scenarios use a structure of shocks that is thought to be plausible, but has not yet occurred. Each type of scenario has its benefits. Depending on the risks, both approaches could be of value and should thus be used. [Related definitions: <i>Deterministic scenario, Stochastic modelling, Stress testing</i> ]	Энэхүү сорил нь хэд хэдэн эрсдлийн хүчин зүйлүүдийн нэгэн зэрэг өөрчлөлтийг авч үздэг ба энэ нь ихэнхдээ бодит байдлын өөрчлөлттэй шууд холбогддог.  Хувилбарт сорил нь ихэнхдээ гамшгийн тохиолдлын улмаас даатгагчийн санхүүд үзүүлэх нөлөөллийг шинжилдэг. Үүнд ялангуяа тодорхой газар нутагт болох гамшиг, эсхүл даатгагчийн бүх бизнест, эсхүл үйл ажиллагаанд нөлөөлөх (андеррайтинг хэмжээ, хувьцааны үнэ, зээлийн хүүний өөрчлөлт) хэд хэдэн эрсдлийн зүйлийн нэгэн зэрэг өөрчлөлтүүд ордог. Түүхэн болон таамаглалт гэсэн үндсэн 2 хувилбар байдаг.  Түүхэн хувилбар нь түүхийн тодорхой үзэгдэлд тохиолдсон эрсдлийн хүчин зүйлийн өөрчлөлтүүдийг тусгадаг.  Таамаглалт хувилбар нь учрах боломжтой боловч хараахан тохиолдоогүй байгаа цочролын бүтцийг ашигладаг.  Дээрх хувилбарууд нь өөр өөрийн давуу талуудтай ба хувилбарыг тухайн эрсдлээс хамааруулан сонгон хэрэглэдэг.
141	<b>Securitization – үнэт цаасжуулалт</b>	Involves a simple financial concept: the future cash flows that can be expected from a particular source (e.g., receivables or loan repayments) serve to back up a financial instrument for sale to an investor. When a business entity (originator) engages a securitization, it first transforms the cash flows into a tradable instrument and then transfers the attendant risk from the entity to capital market investors who, in turn, expect a return commensurate with the risks.	Санхүүгийн энгийн ойлголтыг агуулна: хөрөнгө оруулагчдад худалдах санхүүгийн хэрэгслийг баталгаажуулж байгаа тодорхой эх үүсвэрээс (тухайлбал, авлага, зээлийн эргэн төлөлт) бий болох ирээдүйн мөнгөн урсгал. Хуулийн этгээд (үүсгэн байгуулагч) үнэт цаас гаргахаар бол эхлээд мөнгөн гүйлгээгээ арилжаалагдах хэрэгсэл болгоод дараа нь өөрийн компанийн эрсдлийг хөрөнгийн зах зээл дээрх хөрөнгө оруулагчдад шилжүүлдэг. Үүний хариуд тэд тухайн эрсдэлтэй нь тохирсон хэмжээний ашиг хүлээж байдаг.

142	<b>Semi-automatic facultative reinsurance – хэсэгчлэн биелүүлэх факультатив давхар даатгал</b>	Requires the reinsurer to accept certain defined risks of the reinsured, subject to the right of the reinsurer to reject liability for any of such risks within a stated period after submission. Like facultative obligatory reinsurance, semiautomatic facultative reinsurance is also a hybrid of both treaty and facultative reinsurance.	Эрсдлийг хүлээн авсны дараа тохиролцсон хугацаанд хариуцлага үүрэхээс татгалзах эрхтэйгээр тусгайлан заасан эрсдлүүдийг шилжүүлдэг давхар даатгал  Энэ даатгал нь факультатив заавал давхар даатгалын адил “гэрээний” болон факультатив давхар даатгалын холимог шинжийг агуулсан байдаг.
143	<b>Senior management – дээд удирдлага</b>	The individuals or body responsible for managing the business on a day-to-day basis in accordance with strategies, policies and procedures set out by the Board.	ТУЗ-ээс гаргасан стратеги, бодлого, журмын дагуу бизнесийг өдөр тутмын удирдлагаар хангаж байдаг хүмүүс, эсхүл байгууллага
144	<b>Sensitivity tests – мэдрэмжийн сорил</b>	Examines the effect of changing one or a few variables rather than considering a full alternative scenario.	Бүтэн хувилбарт тест хийхгүйгээр нэг, эсхүл хэд хэдэн хувьсагчийн өөрчлөлтөөс үүсэх нөлөөллийг шинжлэх
145	<b>Shock period – цочролын үе</b>	The period over which a shock is applied to a risk. [Related definition: <i>Effect horizon</i> ]	Эрсдэл үүсгэсэн цочролын үйлчлэх хугацаа  Холбоотой нэр томъёо: Мэдлэгийн нөлөөлөл
146	<b>Significant influence- Голлох нөлөөлөл</b>	For the purpose of group-wide supervision, this represents a level of direct/indirect control or effect over the strategic operating, investing, and financing policies of an insurer.	Энэ нь группын хэмжээнд зохицуулалт хийх зорилгоор даатгагчийн стратегийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, болон санхүүжилтын бодлогод хийх шууд болон шууд бус хяналтын түвшинг илэрхийлдэг.
147	<b>Significant owner – голлох өмчлөгч</b>	A significant owner is defined as a person (legal or natural) that directly or indirectly, alone or with an associate, exercises control over the entity.	Голлох өмчлөгч гэж байгууллагыг шууд болон шууд бусаар, ганцаарчилж эсхүл бусадтай хамтарч хянадаг хүнийг хэлнэ.
148	<b>Solvency – төлбөрийн чадвар</b>	Ability of an insurer to meet its obligations to policyholders when they fall due. Solvency includes capital adequacy but also involves other aspects of a solvency regime, for example, technical provisions, qualitative aspects (such as would be addressed in an enterprise risk management framework), supervisory review and supervisory reporting. [Equivalent term: <i>Financial health</i> ]	Даатгагчаас даатгуулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх чадвар.  Төлбөрийн чадварт өөрийн хөрөнгийн зохистой байдлаас гадна байгууллагын эрсдлийн менежментийн хүрээнд хамаарах чанарын асуудлууд, техникийн нөөц, Зохицуулалтын байгууллагын хяналт шалгалт, түүний тайлан зэрэг төлбөрийн чадвартай холбоотой бусад зүйл мөн хамаардаг.  [Ижил утгатай нэр томъёо: <i>Санхүүгийн эрүүл байдал</i> ]
149	<b>Solvency assessment- төлбөрийн чадварын үнэлгээ</b>	A process for measuring the current and possible future solvency of an insurer relative to the level of policy holder protection required by the solvency regime. It encompasses the assessment of the effectiveness of an insurer's enterprise risk management within the constraints placed on the insurer's operation and the adequacy of the insurer's financial resources, including capital resources.	Төлбөрийн чадварын шаардлагын дагуу даатгуулагчийг хамгаалах түвшинтэй уялдуулан даатгагчийн одоогийн болон ирээдүйн боломжит төлбөрийн чадварыг хэмжих үйл явц.  Үүнд даатгагчийн хөрөнгийн нөөц, санхүүгийн нөөцийн зохистой байдал болон даатгагчийн үйл ажиллагааны хязгаарлалтын хүрээнд байгууллагын эрсдлийн удирдлагын үр ашигтай байдлын үнэлгээ багтдаг.
150	<b>Solvency margin- төлбөрийн чадварын хязгаар/</b>	Surplus of assets over liabilities. (Because these terms are frequently used in an imprecise manner, the glossary refers to available solvency (margin) or available surplus capital and required solvency margin or required surplus.) [Equivalent term: <i>Surplus capital</i> ]	Өр төлбөрөөс давсан хөрөнгийн хэмжээ. Үүнийг бололцоот төлбөрийн чадвар /зөрүү/, бололцоот илүүдэл хөрөнгө болон шаардагдах төлбөрийн чадварын хязгаар, эсхүл шаардагдах илүүдэл хөрөнгө гэсэн нэр томъёонуудаар илэрхийлдэг.  Ижил утгатай нэр томъёо: <i>Илүүдэл хөрөнгө</i>
151	<b>Solvency requirements - төлбөрийн</b>	The whole set of requirements set by the solvency regime.	Төлбөрийн чадварын журмын дагуу тогтоосон багц шаардлагууд.

	<b>чадварын шаардлага</b>		
152	<b>Solvency test – төлбөрийн чадварын сорил</b>	The test showing compliance with domestic solvency requirements at a certain point in time (e.g. as of the balance sheet date), either by following a static approach, i.e. by comparing available solvency margin with required solvency margin (i.e. the test must show AS > RS), or by following a dynamic approach, i.e. an actuarial test based on certain assumptions as to the risk parameters of the existing and potential future portfolio (e.g. mortality, investment yield, distribution of losses, expenses).	Тодорхой цаг хугацааны (тайлан тэнцлийн хугацаагаар) төлбөрийн чадвар шаардлагад нийцэж байгаа эсэхийг харуулсан сорил. Үүнийг статик болон динамик хандлагыг ашиглаж гүйцэтгэдэг. Статик хандлагаар бодит төлбөрийн чадварын хязгаарыг шаардагдах төлбөрийн чадварын хязгаартай харьцуулдаг. Сорилоор бодит төлбөрийн чадвар нь шаардагдах төлбөрийн чадвараас их байх ёстой. Динамик хандлага нь одоогийн болон ирээдүйн боломжит багцын (нас баралтын түвшин, хөрөнгө оруулалтын өгөөж, хохирлын тархалт, зардлууд) эрсдлийн параметр төсөөлөлд тулгуурласан актуарын сорил юм.
153	<b>Special Purpose Entity – Тусгай зорилготой байгууллага</b>	A corporation, trust, or other entity organised by an insurer for a specific purpose, the activities of which are limited to those appropriate to accomplish the purpose of the SPE, and the structure of which is intended to isolate the insurer from the risks of the said activities. As part of its risk mitigation strategy, an insurer may transfer some of the risk on its balance sheet to an off-balance sheet structure, variously referred to as Special Purpose Entity (SPE), Special Purpose Vehicle (SPV), Special Purpose Reinsurance Vehicle, Special Purpose Insurer, etc. The term SPE is used throughout the ICPs, standards and guidance to cover all such entities.	Тусгай зориулалтын хуулийн этгээд нь зорилгодоо заасан үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлагддаг, бүтэц зохион байгуулалт нь тухайн үйл ажиллагааны эрсдлийг даатгагчаас тусгаарлах зорилгоор даатгагчийн байгуулсан корпораци, итгэлцлийн, эсхүл бусад байгууллага хэлбэртэй байна.  Эрсдлийг бууруулах бодлогын хүрээнд даатгагч баланс дээрх зарим эрсдлийг балансын гадуурх бүтцэд шилжүүлж болно.  Үүнийг тусгай зориулалтын хуулийн этгээд ТЗХЭ (SPE), тусгай зориулалтын хэрэгсэл (SPV), тусгай зориулалтын давхар даатгалын хэрэгсэл, тусгай зориулалтын даатгагч гэх мэтээр нэрлэдэг.  ТЗХЭ гэсэн нэр томъёо нь даатгалын хяналтын тулгуур зарчмууд, стандарт, заавруудад энэ төрлийн байгууллагуудыг төлөөлөн хэрэглэгддэг.
154	<b>Statistical quality test – статистикийн чанарын сорил</b>	A test to assess the base quantitative methodology of the internal model, which demonstrates the appropriateness of the model inputs and parameters and justifies the assumptions underlying the model.	Загварын үндсэн таамаглалыг батлах, орц ба параметруудийн нийцлийг илэрхийлдэг дотоод загварын суурь тоон арга зүйг үнэлэх сорил.
155	<b>Stochastic modeling – стохастик загварчлал</b>	A methodology which aims at attributing a probability distribution to financial variables of interest. It sometimes uses closed form solutions, often involves simulating large numbers of scenarios in order to reflect the distributions of the capital required by, and the different risk exposures of, the insurer. [Related definitions: <i>Scenario test, Stress testing</i> ]	Санхүүгийн хувьсагч хэмжигдэхүүнүүдэд магадлалын тархалтыг харгалзуулахад чиглэсэн арга зүй. Үүнд заримдаа даатгагчийн янз бүрийн эрсдэлд өртөх байдал болон шаардагдах хөрөнгийн тархалтыг харуулахын тулд олон тооны хувилбарт сорилын симуляци бүхий хаалттай хэлбэрийн шийдлийг хэрэглэдэг.  Холбоотой нэр томъёо: <i>Хувилбарт сорил, Стресс сорил</i>
156	<b>Stop-loss reinsurance (life and health) Алдагдлыг зогсоох давхар даатгал</b>	Commonly used to describe coverage for a collection of insurance risks under which, once the ceding company pays the total amount of all claims in a specified period, usually a calendar year, up to a total aggregate limit determined in advance for the period, the reinsurer will reimburse a specified proportion (e.g. 90%) of the amount in excess of the aggregate retention	Даатгалын компани тодорхой заасан хугацаанд, ихэвчлэн хуанлийн жилд урьдчилан тохиролцсон нийт хязгаар хүртэл бүх хохирлыг төлж, даатгагчийн тухайн хугацаанд өөртөө авч үлдсэн хохирлын нийлбэр дүнгээс давсан хэсгийг давхар даатгагч тодорхой хувь хэмжээгээр (ж.нь 90%) даатгагчид нөхөн төлдөг. Практик дээр, аливаа хүний амь насны нөхөн



		for the period, subject to a maximum reinsurance limit. In practice, the maximum amount of claim on any one life is usually "warranted" by the ceding company. Any policy amounts issued in excess of the warranted maximum are reinsured conventionally.	төлбөрийн дээд хэмжээ нь ихэвчлэн седант компаниар "баталгаажсан" байдаг. Амь насны даатгалын гэрээний дүнгийн баталгаажсан дээд дүнгээс давсан хэсэг нь давхар даатгагддаг.
157	<b>Stress testing – стресс тест</b>	The method of solvency assessment that provides for the consideration of the impact (current and prospective) of a particular defined set of alternative assumptions or outcomes that are adverse. Consideration is given to the effect on the insurance company assets, liabilities and operations of a defined adverse scenario. [Related definitions: <i>Deterministic scenario, Scenario test, Stochastic modelling</i> ]	Үр дүн болон төсөөллүүд нь сөрөг үр дагавартай байх, урьдчилан тодорхойлсон сонголтуудын одоогийн ба хэтийн нөлөөллийг авч үзэх зорилгоор хийгддэг төлбөрийн чадварын үнэлгээний арга. Ингэж үнэлэхдээ даатгалын компаний хөрөнгө, өр төлбөр, үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг илүү авч үздэг.  Холбоотой нэр томъёо: <i>Детерминистик хувилбар, Хувилбарт сорил, Стохастик загвар</i>
158	<b>Subgroup college – дэд бүлгийн зөвлөл</b>	A supervisory college established at the level of a subgroup of an insurance group.	Даатгалын группын дэд бүлгийн түвшинд байгуулагддаг хяналтын зөвлөл.
159	<b>Subordinated loans – 2-р зэргийн зээл</b>	Loans (liabilities) that rank after the claims of all other creditors and which are to be paid, in the event of liquidation or bankruptcy, only after all other debts have been met.	Компани дампуурах, эсхүл татан буугдах үед нэхэмжлэлүүдийн хамгийн сүүлд бичигддэг, бүх өр төлбөрүүдийг төлсний дараа төлөгдөх, зээл /өр/.
160	<b>Suitability – тохиромжтой байдал</b>	Necessary qualities that must be exhibited by a person performing the duties and carrying out the responsibilities of his/her position with an insurer. Depending on his or her position or legal form these qualities could relate to a proper degree of integrity in attitude, personal behaviour and business conduct, soundness of judgment, degree of knowledge, experience and professional qualifications and financial soundness.	Даатгалын байгууллагын ажилтны үүргээ гүйцэтгэж, хариуцлага хүлээх чадварыг илтгэх зайлшгүй шаардлагатай шинж чанарууд.  Эдгээр шинж чанарууд нь албан тушаалаас хамааран хувь хүний зан байдал, хандлага, асуудлыг шийдвэрлэх чадвар, мэдлэгийн түвшин, санхүүгийн байдал, мэргэжлийн үр чадвар, туршлага зэрэгтэй холбогдоно.
161	<b>Supervisory college – хяналтын зөвлөл</b>	A forum for cooperation and communication between the involved supervisors established for the fundamental purpose of facilitating the effectiveness of supervision of entities which belong to an insurance group; facilitating both the supervision of the group as a whole on a group-wide basis and improving the legal entity supervision of the entities within the insurance group.	Даатгалын группт хамаарах байгууллагуудын хяналтыг сайжруулах, группын хэмжээнд хяналт тавих зорилгоор байгуулагдсан хяналтын байгууллагуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааны хэлбэр.
162	<b>Supervisory financial reports – Зохицуулалтын санхүүгийн тайлан</b>	Financial reports prepared according to accounting principles set out by the supervisor and may wholly or partially be based on general purpose financial reporting.	Зохицуулалтын байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан бөгөөд энэ нь санхүүгийн тайланд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн үндэслэсэн байж болно.
163	<b>Surplus capital – илүүдэл хөрөнгө</b>	see Solvency margin	"Төлбөрийн чадварын хязгаар"-тайлбарыг үзнэ үү.
164	<b>Surplus relief- нэмэлт дэмжлэг</b>	A method of deferring losses or accelerating future profits on a block of in-force or new insurance business. This can be done in three ways:  i) reinsurer pays an amount equal to its best estimate value of all future margins and takes all future income, however there is no	Даатгалын одоо хүчинтэй байгаа, эсхүл шинэ бизнесийн ирээдүйн үр ашгийг түргэтгэх, эсхүл хохирлыг бууруулах арга юм. Үүнийг 3 янзаар хийж болно:  • Давхар даатгагч ирээдүйд олох ашгийг хамгийн дээд хэмжээгээр төлөх ба ирээдүйн бүх орлогыг авах боловч буцааж олгодоггүй.

		<p>experience refund. This is a traditional risk transfer in that the reinsurer is taking a risk that the profit may not emerge as projected.</p> <p>ii) reinsurer pays initial expenses, has a charge over all emerging surplus and returns excess surplus through the experience account. In this situation the reinsurer will suffer a loss if the profits do not emerge as projected. The reinsurance agreement does not limit the loss exposure to the reinsurer. If the profits are over a certain level, these are returned to the cedant via the experience account, which caps the reinsurer's potential for profit. This is a finite reinsurance transaction.</p> <p>iii) reinsurer pays an upfront amount, takes a charge over future margins, however if the margins do not emerge the cedant has an obligation to make payments from sources outside the reinsured business. This should be treated as a loan.</p>	<p>Энэ нь эрсдлийг шилжүүлэх уламжлалт арга бөгөөд төлөвлөсний дагуу ашиг орж ирэхгүй байх эрсдлийг давхар даатгагч үүрч байдаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Давхар даатгагч эхний зардлуудыг төлж, үүссэн илүүдлээс шимтгэл авдаг ба илүүдлээс давсан хэсгийг туршлагын дансаар буцаан олгодог.</li> </ul> <p>Энэ нөхцөлд төлөвлөсний дагуу ашиг орж ирэхгүй бол хохирлыг давхар даатгагч өөртөө хүлээдэг.</p> <p>Давхар даатгалын гэрээгээр давхар даатгагчид учирч болох хохирлын хэмжээг хязгаарладаггүй.</p> <p>Хэрэв ашиг нь заасан төвшнөөс давсан бол даатгагчид туршлагын дансаар буцаан олгоно. Үүнийг давхар даатгалын хязгаарлагдмал шилжүүлэг гэнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Давхар даатгагч тодорхой хэмжээний урьдчилгаа төлөөд ирээдүйн ашгаас шимтгэл авах ба хэрэв ашиг гарахгүй бол даатгагч давхар даатгалын бизнесээс гадуурх эх сурвалжаас төлбөр төлөх үүрэг хүлээнэ. Үүнийг зээл гэж үздэг.</li> </ul>
165	<b>Surplus share reinsurance – хувьсах оролцооны давхар даатгал</b>	<p>This type of proportional reinsurance is a variation on the quota share concept. Instead of sharing every policy on the basis of a never-changing fixed ratio, a surplus agreement permits the insurer to cede varying amounts or percentage shares of each original policy to the reinsurer. The amounts ceded are still subject to a stipulated minimum retention and maximum cession. Once a cession has been made to the surplus treaty, premiums, expenses and losses will be shared proportionally between the insurer and the reinsurer.</p>	<p>Энэ нь шууд хамааралтай давхар даатгалын нэг хэлбэр.</p> <p>Энэ хэлбэрийн үед даатгалын гэрээ тус бүрийг өөрчлөгддөггүй тогтмол харьцаагаар бус харилцан адилгүй хэмжээ, хувиар давхар даатгагчид шилжүүлэх боломжтой.</p> <p>Давхар даатгалд шилжүүлж буй дүн нь даатгагчийн өөрийн хариуцах доод хэмжээ болон шилжүүлгийн дээд хэмжээг заадаг.</p> <p>Даатгагч болон давхар даатгагч нь энэ гэрээгээр давхар даатгалын шилжүүлэг хийхдээ хураамж, зардал, хохирлыг шууд хамааралтайгаар хуваалцдаг.</p>
166	<b>Swap- своп \солилцоо\</b>	<p>A financial transaction in which two counterparties agree to exchange streams of payments over time according to a predetermined rule. The most common form of swap is a "vanilla" interest rate swap. With that structure, one party pays interest at a fixed rate while the other pays according to a floating rate such as LIBOR.</p>	<p>Талууд урьдчилан тохирсон дүрмийн дагуу тодорхой хугацаанд төлбөр солилцохоор тохиролцсон санхүүгийн хэлцэл.</p> <p>Свопын хамгийн өргөн хэлбэр нь "ванилла" хүүгийн своп юм.</p> <p>Энэ бүтцээр нэг тал нь тогтмол хүү, нөгөө тал хувьсах хүү тухайлбал, Лондонгийн банк хоорондын захын суурь хүүгээр гэх мэт төлдөг.</p>
167	<b>Tail Value at Risk (TVaR or Tail VaR) – үргэлжлэл бүхий хүлээж болзошгүй алдагдлын хэмжээ</b>	<p>Value at risk (VaR) plus the average excess over the VaR if such excess occurs over a specified amount of time. Sometimes also called "Conditional value at risk", it asks the question "If things do get bad, how much can we expect to lose?"</p>	<p>Энэ нь хүлээж болзошгүй алдагдлын хэмжээн (VaR) дээр түүнээс давсан хэсгийн (хэрэв энэ давсан хэсэг нь өгөгдсөн тухайн хугацаанд бий болж байгаа бол) дунджийг нэмсэн дүн. Үүнийг зарим тохиолдолд "нөхцөлт VAR" гэж нэрлэдэг ба "хэрэв нөхцөл байдал дордвол бид ямар хэмжээний алдагдал хүлээх вэ?" гэсэн асуултыг тавьдаг байна.</p>
168	<b>Takaful- Такафул</b>	<p>Insurance conducted according to relevant Islamic principles.</p>	<p>Исламын зарчмын дагуу хэрэгжүүлж буй даатгал</p>
169	<b>Technical liabilities – техникийн хариуцлага</b>	<p>see <b>Technical provision</b></p>	<p>"Техник нөөц" гэсэн тайлбарыг харна уу.</p>

170	<b>Technical provisions – техникийн нөөц</b>	The amount that an insurer sets aside to fulfil its insurance obligations and settle all commitments to policyholders and other beneficiaries arising over the lifetime of the portfolio, including the expenses of administering the policies, reinsurance and of the capital required to cover the remaining risks. [Equivalent terms: <i>Policy liabilities, Technical liabilities</i> ]	Даатгагч өөрийн багцын хүчинтэй хугацаанд үүсч болох даатгуулагч болон даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор тусгаарласан мөнгөн хөрөнгө. Үүнд гэрээний үүргийг хэрэгжүүлэх, давхар даатгал болон үлдэж буй эрсдлийг давахад шаардагдах хөрөнгийн зардал багтана.  Ижил утгатай нэр томьёо: гэрээний хариуцлага, техникийн хариуцлага
171	<b>Technical risks – техникийн эрсдэл</b>	Represent the various kinds of risk that are directly or indirectly associated with the technical or actuarial bases of calculation for premiums and technical provisions in both life and non-life insurance, as well as risks associated with operating expenses and excessive or uncoordinated growth. Technical risks result directly from the type of insurance business transacted. They differ depending on the class of insurance. Technical risks exist partly due to factors outside the company's area of business activities, and the company often may have little influence over these factors. The effect of such risks - if they materialise - is that the company may no longer be able to fully meet the guaranteed obligations using the funds established for this purpose, because either the claims frequency, the claims amounts, or the expenses for administration and settlement are higher than expected. [Equivalent term: <i>Insurance risk</i> ]	Амьдралын ба амьдралын бус даатгалын техникийн нөөц болон хураамжийг тооцоолоход техникийн болон актуар тооцооллын суурьтай шууд ба шууд бусаар холбоотой, мөн үйл ажиллагааны зардал, түүнчлэн хэт их, эсхүл тэнцвэргүй өсөлттэй холбогдон үүсдэг төрөл бүрийн эрсдлүүдийг хэлнэ.  Техник эрсдлүүд нь даатгалын бизнесийн төрлөөс шууд хамаардаг бөгөөд харин даатгалын ангиллаас хамаарч өөр өөр байна.  Техник эрсдлүүд заримдаа компанийн явуулж байгаа бизнесийн хүрээнээс гадуурх хүчин зүйлээс хамаардаг ба компани тэдгээр хүчин зүйлд нөлөөлөх чадвар маш бага байдаг.  Тэдгээр эрсдлүүд бодитоор учирвал даатгагч даатгалын үүргээ биелүүлэх зорилгоор үүсгэсэн сангаараа хариуцлагаа хүлээж чадахгүй болох үр дагавар үүсэх боломжтой. Учир нь нэхэмжлэлийн давтамж, нэхэмжлэлийн дүн, нэхэмжлэлийг шийдвэрлэхэд гарах зардлууд нь төлөвлөж байснаас өндөр байдаг. [ижил утгатай нэр томьёо: <i>даатгалын эрсдэл</i> ]
172	<b>Terrorist financing – терроризмыг санхүүжүүлэх</b>	The willful provision or collection of funds, by any means, directly or indirectly, with the unlawful intention that the funds should be used, or in the knowledge that they are to be used, in whole or in part: • to carry out a terrorist act(s) • by a terrorist organization, or • by an individual terrorist.	Хууль бус зорилгоор ямар нэг хэлбэрээр, шууд ба шууд бус аргаар, мөнгөн хөрөнгө бүрдүүлж, түүнийг бүхэлд нь буюу хэсэгчлэн дараахь зүйлд хэрэглэх, хэрэглэхээр төлөвлөх: • Террорист үйл ажиллагаа явуулах • Террорист байгууллага, хүнийг санхүүжүүлэх
173	<b>Tolerance limits – Эрсдэл даах хязгаар</b>	The level of risk to which the insurer is prepared to be exposed. The risk measure might be a supervisory one or an internal one or a combination of both.	Даатгагчийн хүлээхэд бэлэн байгаа эрсдлийн түвшин. Эрсдлийн хэмжүүр нь зохицуулах байгууллагын, дотоодын, эсхүл эдгээрийн хослол байж болно.
174	<b>Total balance sheet approach – Нийт тайлан тэнцлийн хандлага</b>	A concept which recognises the interdependence between all assets, all liabilities, all regulatory capital requirements and all capital resources. A total balance sheet approach should ensure that the impacts of all relevant material risks on an insurer's overall financial position are appropriately and adequately recognised. It is noted that the total balance sheet approach is an overall concept rather than implying use of a particular methodology.	Үндсэн хөрөнгө, өр төлбөр, зохицуулах байгууллагын шаардсан хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэрийн хоорондын харилцан хамаарлыг тодорхойлох зарчим.  Нийт тайлан тэнцлийн хандлага нь даатгагчийн санхүүгийн байдал түүнд хамааралтай материаллаг эрсдлүүдийн нөлөөлөл нь зөв, зохистойгоор тусгагдсан гэдгийг тодорхой болгож өгдөг. Энэ хандлага нь тодорхой нэг аргачлалыг ашиглахаас илүүтэй ерөнхий зарчим юм.
175	<b>Treaty reinsurance (non-life) –</b>	Usually automatic arrangements in that the insurer does not have to make specific cessions in order to activate reinsurance	Даатгагч давхар даатгалын хамгаалалтыг хүчин төгөлдөр болгохын тулд тусгайлан шилжүүлэг хийх шаардлагагүй байдаг шууд

	<p><b>гэрээ хэлбэрийн давхар даатгал /ердийн даатгал/</b></p>	<p>protection. Exceptions to this general rule are special acceptances, a procedure by which risks that do not qualify for coverage under the terms and conditions of the treaty may be submitted to the reinsurer for specific underwriting evaluation and determination of any additional premium charge. Treaties are also usually obligatory, in that the cedant is obligated to cede all business defined by the reinsurance agreement, and the reinsurer is obligated to accept all such business, subject to the terms and conditions of the contract. Surplus treaties are sometimes non-obligatory from the insurer's standpoint as the insurer may elect not to cede a specific risk, or to cede something less than the maximum cession permitted under the contract provisions. Treaty reinsurance usually applies to a broad segment of the insurer's overall book of business (e.g., all Workers' Compensation business, all Commercial Property business, all Accident &amp; Health business, all Aviation business, etc.). All sorts of segregations are possible, but the idea is to group together entire lines or classes of business. As long as the business to be reinsured is reasonably homogeneous in nature or exposed to loss arising from a common cause and written in sufficient volume it can be considered for treaty reinsurance. A sufficient volume of reinsurance is necessary in order to satisfy the reinsurers' need to collect reinsurance premiums that bear a reasonable relationship to the assumed liabilities. Treaty reinsurance is considered to be the most efficient and least expensive way of arranging for such transfers.</p>	<p>биелүүлэх тохиролцоо. Энэ ерөнхий зарчимд хамаарахгүй нөхцөлүүд гэвэл гэрээ хэлбэрийн нөхцөлд заасан эрсдлийн шаардлагад үл нийцэх давхар даатгагчид шилжүүлэгдэх эрсдлүүд нь нэмэлт хураамжаар тусгай андеррайтингийн үнэлгээ хийлгэн тусгайлан хүлээн авагддаг процедур юм. Трити давхар даатгал нь ихэвчлэн заавал даатгал байдаг бөгөөд даатгагч гэрээгээр тохиролцсон бүхий л бизнесүүдээ давхар даатгагчид шилжүүлэх, давхар даатгагч нь гэрээгээр тохиролцсон нөхцөлийн дагуу уг эрсдлүүдийг бүгдийг хүлээн авах үүрэг хүлээдэг. Давсан дүнгийн трити давхар даатгалын гэрээ нь заримдаа даатгагчийн зүгээс заавал бус байдаг бөгөөд даатгагч нь зарим тусгай эрсдлүүдийг шилжүүлэхгүй буюу гэрээний нөхцөлд тохирсон шилжүүлгийн дээд хэмжээнээс багаар шилжүүлж болдог. Гэрээний давхар даатгал нь ихэнхдээ даатгагчийн нийт бизнесийн өргөн хүрээтэй даатгалуудад (тухайлбал, ажил олгогчийн хариуцлагын даатгал, байгууллагын хөрөнгийн даатгал, гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал, онгоцны даатгал гэх мэт) хамаардаг. Дотор нь төрөл бүрээр салгаж болох боловч даатгалын төрөл, хэлбэрүүдээр бүгдийг хамтад нь бүлэглэх нь гол санаа болно. Давхар даатгагдах бизнесүүд нь мөн чанараараа ижил төрлийн шинжтэй буюу ерөнхий шалтгааны улмаас хохирол гарах боломжтой, хангалттай тоо хэмжээгээр хийгддэг бол трити давхар даатгалыг хэрэглэх нь зохистой гэж үздэг. Хүлээж буй хариуцлагатай харилцан хамаарал бүхий хэмжээний давхар даатгалын хураамж цуглуулах давхар даатгагчийн хэрэгцээг хангахын тулд давхар даатгалд шилжүүлэх хангалттай тоо хэмжээтэй байх шаардлагатай. Трити давхар даатгал нь эрсдлийг шилжүүлэх хамгийн үр ашигтай, хамгийн бага зардалтай аргад тооцогддог.</p>
176	<p><b>Unbundling (Bifurcation) – Задаргаа хийх</b></p>	<p>For accounting purposes, unbundling is the separation of a contract into financing and risk transfer components.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор гэрээг санхүүгийн бүрэлдэхүүн болон эрсдлийг шилжүүлэх бүрэлдэхүүнээр задлан хуваах.</p>
177	<p><b>Underwriting year basis – Андеррайтингийн жилийн суурь</b></p>	<p>Accounting figures - for instance, claims incurred - are based on the contracts underwritten in the accounting period. [Related definitions: <i>Claims development triangle, Claims provision</i>]</p>	<p>Бүртгэлийн дүнгүүд нь, тухайлбал учирсан хохирлын дүн нь тайлант хугацаанд байгуулагдсан даатгалын гэрээнд суурилдаг.  <i>Холбоотой нэр томъёо: нэхэмжлэлийн хөгжлийн гурвалжин, нэхэмжлэлийн нөөц</i></p>
178	<p><b>Underwriting risk – андеррайтингийн эрсдэл</b></p>	<p>Includes claims, expense and reserving risks and the risks associated with guarantees and options embedded in policies.</p>	<p>Үүнд нэхэмжлэлийн, зардлын болон нөөцийн эрсдлүүд, мөн даатгалын гэрээнд шигтгэсэн (багтаасан) опшин, баталгаатай холбогдон гарах эрсдлүүд багтана.</p>
179	<p><b>Use test – ашиглалтын сорил</b></p>	<p>A supervisory process to access whether the internal model, its methodologies and results, are appropriately embedded into the insurer's risk strategy, risk management, and operational processes.</p>	<p>Дотоод загвар, түүний аргачлал болон үр дүн нь даатгагчийн эрсдлийн стратеги, эрсдлийн удирдлага, үйл ажиллагаанд зохих ёсоор тусгагдсан эсэхийг үнэлэх хяналтын үйл явц.</p>
180	<p><b>Value at risk (VaR) – хүлээж</b></p>	<p>An estimate of the worst expected loss over a certain period of time at a given confidence level.</p>	<p>Өгөгдсөн итгэлцлийн түвшинд тодорхой цаг хугацааны туршид учирч болох хамгийн их хохирлын үнэлгээ</p>

	<b>болзошгүй алдагдлын хэмжээ</b>		
181	<b>Whistle blowing – шүгэл үлээх</b>	The exposure and reporting of misconduct carried out by a member of the public or within an insurer by a Board Member, Senior Manager or other member of staff.	Нийтийн (улсын), эсхүл даатгалын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, ахлах менежер болон бусад ажилтнуудын албан тушаалын сахилга зөрчсөн байдлыг мэдээлэх болон илчлэх.
182	<b>Wrong way risk- Буруугаар эргэх эрсдэл</b>	The risk that occurs when exposure to counterparties, such as financial guarantors, is adversely correlated to the credit quality of those counterparties.	Санхүүгийн батлан даагчид гэх мэт хамтрагч талууд эрсдэлд өртөх нь эргээд тэдгээр хамтрагчдын зээлийн чанарт сөргөөр нөлөөлөх үед гарах эрсдэл
183	<b>Yearly renewable term (YRT) or Risk premium reinsurance basis – жилээр сунгагдах нөхцөл, эсхүл эрсдэл тооцсон хураамж дээр суурилсан давхар даатгал</b>	Reinsurance arrangements written on this basis transfer the mortality risk to the reinsurer. For every age, plan, and policy year, there is a certain reserve per \$1,000 of insurance. In calculating the insurer's available surplus capital, this is the liability that is deducted from assets to arrive at the insurer's available surplus capital. Since this reserve amount is already in the insurer's liabilities, it is clear that if the insurer is called upon to pay more than this amount, only the excess over the reserve needs to be taken from the insurer's available surplus capital. In the event of a death claim, assets are reduced by the face amount paid, liabilities are reduced by the reserve amount, and the excess of the face amount over the reserve comes from its available surplus capital. This excess is called the "policy net amount at risk." In the reinsurance agreement the ceding company and the reinsurer agree upon how the policy net amount at risk will be apportioned between them. The ceding company would prepare a schedule of the net amounts at risk for each policy year. The reinsurer would develop a schedule of yearly renewable term premium rates for reinsurance on the ceding company's schedule. The ceding insurer would pay the reinsurer the established premiums for the appropriate net amounts at risk each year. In the occurrence of a claim, the reinsurer would remit payment for the assumed portion of the policy's net amount at risk. Although the policy net amount at risk will decline over time as the policy reserves increase, it is common for the parties to agree to make adjustments only at agreed intervals to ease administration and lower processing costs. This reinsurance method is widely used because it reduces reinsurance to its fundamentals and provides a very flexible mechanism for satisfying the insurer's reinsurance needs.	Энэ сууриар хийгдсэн давхар даатгал нь нас баралтын эрсдлийг давхар даатгагчид шилжүүлдэг. Нас, хамгаалалт болон гэрээний жил тус бүрд даатгалын 1,000\$ тутамд тодорхой хэмжээний нөөц байдаг. Даатгагчийн боломжит илүүдэл хөрөнгийг тооцоолоход дээрх нөөц нь хөрөнгөөс хасагдах хариуцлага болдог. Энэ нөөцийн дүн нь даатгагчийн хариуцлагад хамаарах тул даатгагч энэ дүнгээс давсан хэмжээгээр төлөх тохиолдолд давсан хэсгийг даатгагчийн боломжит илүүдэл хөрөнгөөс гаргуулан авна. Нас барсны нэхэмжлэлийн үед хөрөнгө тал нь гэрээгээр анх тохиролцсон /face amount/, төлсөн дүнгээр буурч, хариуцлага тал нь нөөцийн дүнгээр буурч, нөөцөөс хэтэрсэн, гэрээгээр анх тохиролцсон дүнгээс давсан хэсэг нь энэ боломжит илүүдэл хөрөнгөөс хасч тооцогдоно. Энэ давсан хэсгийг "гэрээний эрсдлийн цэвэр дүн" гэж нэрлэдэг. Давхар даатгалын гэрээгээр даатгагч, давхар даатгагч нар энэхүү гэрээний эрсдлийн цэвэр дүнг хоорондоо хэрхэн хуваарилах талаар тохиролцдог. Даатгагч гэрээний хугацаа бүрд эрсдлийн цэвэр дүнг харуулсан товъёог бэлтгэж өгдөг. Давхар даатгагч нь уг товъёогийг шөдүль ашиглан жил бүр сунгагдах хураамжийн хувь хэмжээг тогтоосон жагсаалт гаргадаг. Даатгагч жил бүр эрсдлийн цэвэр дүнгээс тохирох хураамжийг давхар даатгагчид төлнө. Хохирол гарсан тохиолдолд давхар даатгагч гэрээний эрсдлийн цэвэр дүнгийн ногдох хэсгийг даатгагчид шилжүүлдэг. Жил ирэх тусам нөөц өсөх тул гэрээний эрсдлийн цэвэр дүн нь буурах боловч талууд үйл ажиллагааны зардлыг бууруулах, хялбар байлгах зорилгоор тодорхой хугацаанд өөрчлөлт оруулах талаар тохиролцох нь элбэг байдаг. Энэ төрлийн давхар даатгал нь даатгагчийн давхар даатгалын хэрэгцээг хангах уян хатан механизм болдог тул өргөн хэрэглэгддэг.